

ХУУЛЬ
САХИУЛАХЫН ИХ
СУРГУУЛЬ

МОНГОЛЫН
КРИМИНОЛОГИЧДЫН
ХОЛБОО



ГЭМТ ЯВДАЛТАЙ ТЭМЦЭХ
АСУУДАЛ

ОНОЛ, АРГА ЗҮЙН
УЛИРАЛ ТУТМЫН СЭТГҮҮЛ

2014. №1 (47)



Онол, арга зүйн улирал тутмын сэргүүл

ГЭМТ ЯВДАЛТАЙ ТЭМЦЭХ АСУУДАЛ

ГАРЧИГ

КРИМИНОЛОГИЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

1. Төмөр замын салбарт үйлдэгдэж буй гэмт хэргийг илрүүлэх ажиллагааг хангаж буй нөхцлүүд	4
Д.Мягмарцэрэн, Д.Түвшинтөр.....	
2. Гэмт хэргийн тухай мэдээлэлд боловсруулалт хийх замаар шалтгаан, нөхцлийг	6
тогтоох нь С.Отгонбаатар.....	
3. Хэвлэл мэдээлэл ба аюулгүй байдал Д.Бямбахүү.....	8
4. Нийслэл хот дахь гэмт явдлын чиг хандлага,урьдчилан сэргийлэх арга зам Б.Мөнхдорж.....	11
5. Хууль бусаар хөрөнгөжих гэмт хэргийн шалтгаан, нөхцөл,урьдчилан сэргийлэх арга зам Л.Данзанравжаа.....	16

ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

1. 1921 оны хувьсалаас өмнөх үеийн монголын хууль цаазын түүхэн дэхь ашигт малтмалын	
эрүүгийн эрх зүйн хамгаалал, уламжлал ба шинэчлэлийн асуудал Ж.Нямдулам.....	22
2. Цэрэг татлагаас зайлсхийх гэмт хэргийн ойлголт, бүрэлдэхүүн, зүйлчлэлийн зарим асуудал Л.Бат-Очир.....	25
3. Хүчиндэх гэмт хэргийг төсөөтэй зарим гэмт хэргүүдээс ялган зүйлчлэхэд анхаарах асуудал С.Гантулга.....	29
4. Гэмт хэргийн замаар олсон бохир мөнгийг угаах үйлдлийг	
/эс үйлдэхүй/эрүүжүүлэх үндэслэл, үйл явц Ж.Төгс-Очир.....	33
5. Хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх хэрэгцээ, шаардлага Б.Мэргэн.....	37

ЭРҮҮГИЙН БАЙЦААН ШИЙТГЭХ ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

1. Мөрдөн байцаалтын нууцлал ба мэдээлэл авах эрх Т.Оюунчимэг.....	45
2. Халаасны хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх тактикийн зарим асуудал Т.Болор-Эрдэнэ.....	47

ТАГНАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

1. Тагнах үйл ажиллагааны эрх зүйг хөгжүүлэх асуудал	
Гүйцэтгэх ажлын тухай хууль тогтоомжийн хүрээнд/ Р.Баярмагнай.....	51

ЦАГДААГИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

1. Цагдаагийн хэсгийн байцаагчийн үйл ажиллагааныэрх зүйн зохицуулалтын хөгжил Б.Баянмөнх.....	54
2. Цагдаагийн албан хаагч нь цагдаагийн байгууллагын дотоод аюулгүй байдлыг хангах	
үндсэн хүч мөн Д.Булган.....	57

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

1. Особенности применения мер поощрения в исправительном процессе в отношении	
осужденных отбывающих наказания без изоляции от общества Соколов Сергей Алексеевич.....	61

ЗАХИРГААНЫ ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

1. Германы гэр бүлд гэрлэлтийн гэрээний гүйцэтгэх үүрэг, ач холбогдол С.Гантулга, Х.Гантулга.....	63
2. Монгол Улсын Үндсэн хуулийн мөн чанар, түүний хэрэгжилтийн зарим асуудал Т.Азжаргал.....	66




оны байдлаар 120 түүнээс эмэгтэй нь 30 байна.

2013 онд төмөр замын салбарт бүртгэгдсэн 89 гэмт хэргийн 64% нь хөнгөн, 31.5% нь хүндэвтэр, 2.3% нь хүнд, 2.2% нь онц хүнд гэмт хэргэг байна. Нийт гэмт хэргийн 28.1% нь бусдын бие махбодид гэмтэл учруулах, 29.2% нь бусдын эд хөрөнгийн хулгайлых гэмт хэргэг эзэлж байна. Лхагва гаригт хамгийн их буюу нийт гэмт хэргийн 20% нь үйлдэгдсэн байна. Дээрхи үзүүлэлтээр Баянзүрх дүүрэгтэй харьцуулж үзвэл:

БЗД-т баасан гаргат хамгийн их гэмт хэргэг бүртгэгдсэн байхад төмөр замд лхагва гаргат байна. Баянзүрх дүүрэгт хамгийн их

тодорхой харуулж байгаа бөгөөд төмөр замын салбарт үйлдэгдэж буй гэмт хэрэг илрүүлэх үйл ажиллагааг мэдээллээр хангах нь нийтлэг үйл ажиллагаа боловч зөвхөн энэ салбарт байх өөрийн онцлог байдал. Төмөр замын сүлжээ хөгжсөн, замын нийт урт нь олон арван км зай эзэлдэг, ачаа хүн тээврийн эргэлт маш их улс гүрэнд дээрх үзүүлэлтээс хамааран гэмт хэргийн тоо өндөр байх үндэслэлтэй бөгөөд манай улсын хувьд бусад дүүрэг, аймагт бүртгэн шалгасан гэмт хэргэгтэй харьцуулахад тоон үзүүлэлт бага боловч үйлдлийн арга, гэмт этгээдийн онцлог, илрүүлэх арга барил мэдээллийн урсгалын

түүнээс гол зам 1111 км байна. Талбайн хэмжээ нь 481.5 мянган га газар нутгийг хамаарч байна. Улаанбаатар хотын Баянзүрх дүүргийн газар нутаг дэвсгэрт 124 мянган га газар хамаарч байгаа нь Төмөр замын цагдаагийн газрын харьяа нутаг дэвсгэрээс даруй хоёр дахин бага байгаа бодит байдал байна. Төмөр замын салбарт үйлдэгдэж буй гэмт хэргийн нэгэн чухал зүйл бол гэмт хэргэг үйлдсэн цаг хугацааг зөв тогтоо явдал байдал. Дээр өгүүлсэнчлэн төмөр замын салбарын өөрийн онцлог нь өөрөө тухайн салбарт үйлдэгдсэн гэмт хэргийг илрүүлэхэд бэрхшээл учруулахаас гадна ашигтай байх байдал байдал. Хүмүүс ихээр цугларсан, тусгай хамгаалалттай бусэд бараа бүтээгдэхүүн хадгалагдаж, зөөвөрлөгддөг онцлог нь гэмт хэргийн цаг хугацааг зөв тогтоосноос маш их хамаардаг. Иргэдийн өмчийг хулгайлых гэмт хэргэгт цаг хугацааг түргэн шуурхай тогтоож мэдээлэл цуглувалж гэмт этгээдийг халуун мөрөөр илрүүлэх шаардлага байхад, хамгаалалтын бусэд байгаа бараа бүтээгдэхүүнийг хулгайлах, завших гэмт хэргийг илрүүлэхэд эхэлсэн цаг дууссан цагийг тогтоох нь гэмт хэргийн хүрээ, хохирлын хэмжээ, үйлдлийн аргыг тогтооход ач тустай байдал. Энэ талаар анхны бие даасан судалгаа хийсэн эрдэмтдийн нэг Тарасов-Родионов П.И хэлэхдээ “...гэмт хэргэг үйлдсэн цаг хугацааг зөв оновчтой бодитой тогтоох нь гэмт хэргэг илрүүлэхэд туйлын ач холбогдолтой. Зарим гэмт хэргэг өдөр сар байхад болж байхад, нөгөө хэсэгт нь цаг минут секундээр хэмжигдэхээр тодорхой байдлын шаардлага гардаг байхад зарим тохиолдолд сар жилүүдийг хамарсан байж болно⁶” гэжээ. Төмөр замын салбарт үйлдэгдсэн гэмт хэргэгт цаг хугацааг тогтоосон талаар хийсэн судалгаанд нийт



хувийг бусдын эд хөрөнгийн хулгайлых гэмт хэргэг эзэлж байхад төмөр замд бусдын бие махбодид гэмтэл учруулах гэмт хэргэг эзэлж байна. Дээрхи харьцуулалтын нэг өгөгдэхүүнээр төмөр замын салбарын лхагва гаргайг үйл ажиллагааны хуваарийг судлан үзэхэд Москва-Улаанбаатар, Москва-Улаанбаатар-Бээжин, Бээжин-Улаанбаатар чиглэлийн олон улсын галт тэрэг, Замын-Үүд-Улаанбатар, Сэлэнгэ-Улаанбаатар зэрэг 7 чиглэлийн галт тэрэг ирдэг ба мягмар гаргат ирсэн галт тэрэгний ачаа тээш буудаг байдлаас хүн ачаа тээшний бөөгнөрөл үүсдэг байдал ажиглагдаа. Энэхүү харьцуулалт төмөр замын салбарын онцлогыг

онцлог зэрэг нь салбарын онцлогт хамаардаг байна. Үүнээс дүгнэж үзвэл төмөр замын салбарт үйлдэгдэж буй гэмт хэргийн тоон үзүүлэлт улсын дундаж тоон үзүүлэлтээс бага бөгөөд ангиллын хувьд төрөл бага байгаа байдал ажиглагдаж байгаа нь энэ салбарын онцлогтой шууд холбоотой байгааг илтгэн харуулж байна. Төмөр замд харьялагддаг нутаг дэвсгэр нь төв суурин газрын маш бага хувийг эзэлдэг ба нийт талбайн хэмжээнд зэлүүд эзэнгүй хэсэг ихэнх хувийг эзэлдэгтэй холбоотой юм. Нийт төмөр замын урт 1815 км,

⁴“Монгол Улсад 2003-2013 онд бүртгэсэн гэмт хэргийн статистик үзүүлэлт”. УБ.2013.

⁵“Монгол Улс дахь гэмт хэргэг, захиргааны зөрчлийн нөхцөл байдал 2013”.УБ.2014.

⁶ Тарасов-родионов П.И. Пределы и содержание предварительного следствия /Советская криминалистика на службе следствия. Вып.1. М.,1951.С.43.



ганц хулгай, дээрэм, хүний амь насыг хөнөөх, хүчиндэх хэргүүдээр хязгаарлагддаггүй, мөн санхүүгийн хямрал, ан амьтан, ургамал устах, ус агаар бохирдох, хүн амын өвчлөлт, улс төрийн зөрчилдөөн зэрэг нийгмийн сөрөг үзэгдлүүдийг багтаадаг ба нийгмийн янз бүрийн харилцаануудыг ямар нэг байдлаар зөрчих хэлбэрээр илэрдэг маш өргөн агуулгатай юм.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг оновчтой төлөвлөж гэмт хэргийн гаралт, түүний хор уршгийг бууруулах, саармагжуулахын тулд шинжлэх ухааны үндэслэлтэй урьдчилан сэргийлэх ажлыг өргөн цар хүрээтэй зохион байгуулах явдал чухал юм.

Гэмт явдал, түүний шалтгаан нөхцөл, гэмт хэрэгтэн бие хүн, түүний төлөвшин тогтох таатай болон тааламжгүй нөхцөл байдлууд, тэдгээртэй тэмцэх арга хэмжээний талаарх мэдээ, мэдээллүүдийг цуглуулах, боловсруулах, нэгтгэн дүгнэж дүн шинжилгээ хийх тодорхой арга хэрэгслүүдийг хэрэглэх замаар гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын бодлогыг тодорхойлж чиглэлийг боловсруулах нь зүйтэй.

Гэмт хэргийн шалтгаан нөхцлийг судлах ажиллагааны эцсийн зорилго нь судалгааны ажлын үр дүнг практик амьдралд хэрэглэж гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, нийгмийн сөрөг үзэгдлүүдийг арилгахад чиглэгдсэн арга хэмжээ авах учиртай.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг төлөвлөхдөө дан ганц шалтгаан нөхцлийг судалсан судалгааны ажилд тулгуурлах нь учир дутагдалтай. Учир нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг төлөвлөхөд маш олон төрлийн тоо, баримт, мэдээ, мэдээллүүдийг цуглуулсан байх шаардлагатай байдаг. Үүнд:

1. Урьдчилан гаргасан криминологийн болон бусад шинжлэх ухааны прогноз,

2. Тухайн нутаг дэвсгэрт үйлчилж байгаа болон үйлчлэх хууль эрхийн актууд,

3. Нийгэм, эдийн засаг, улс төр, эрх зүй, удирдлага зохион байгуулалтын талаарх авах арга хэмжээний төлөвлөлт, тэдгээрийн хэрэгжилт,

4. Төлөвлөлт явуулах нутгийн онцлог, хүн ам зүйн байдал, дэд бүтцийн хөгжил,

5. Оршин суугч иргэдийн ёс заншил,

6. Хууль сахиулах, хэрэгжүүлэх байгууллагуудын үйл ажиллагааны талаарх олон нийтийн санаа бодол,

7. Гэмт хэрэг, зөрчилд холбогдож болзошгүй хүмүүсийн тухай, гэмт хэрэг ихээр үйлдэгддэг газруудын талаарх сүүлийн үеийн тоо баримт, судалгаа,

8. Гэмт хэрэг үйлддэг болон үйлдэж болзошгүй шинэ аргуудын мэдээ,

9. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар практикийн байгууллагын ажилтан, эрдэмтэн судлаачдын судалгаа, санал бодол, түүрвисан ном зохиол,

10. Тухайн нутаг дэвсгэрт зохиогдож байгаа баяр ёслол, уулзалт өдөрлөг гэх мэт олон нийтийг хамарсан арга хэмжээний төлөвлөгөө,

11. Урьд нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил зохион байгуулж үр дүнд хүрээгүй шалтгаан нөхцлийг судалж дүгнэлт хийх зэрэг бусад шаардлагатай баримт материалууд байна.

Мөн бус нутаг, салбарын хэмжээний гэмт хэргийн нөхцөл байдалд хийсэн судалгаа, дүн шинжилгээг хамааруулна. Үүнд:

- Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас гэмт хэргийн шинжтэй хүлээн авсан гомдол, мэдээллийн түвшин, түүний шийдвэрлэлт;

- Гэмт хэрэг, түүний динамик /тархалт, өсөлт, бууралт/;

- Гэмт хэргийн ангилал /хөнгөн, хүндэвтэр, хүнд, онц хүнд/;

- Гэмт хэргийн илрүүлэлт /ангиллаар/;

- Гэмт хэрэг үйлдэгдсэн байдал /согтуугаар, бүлэглэн гүйцэтгэсэн, урьдчилан үгсэж тохиролцсон бүлэг үйлдсэн/;

- Үйлдэгдсэн газар, цаг;

- Эрүүгийн хуулийн тусгай ангийн бүлэглэлээр болон тодорхой төрлийн гэмт хэргийн түвшин /тархалт, өсөлт, бууралт/;

- Гэмт халдлагад өртөж хохирсон иргэн, байгууллага, учирсан хор хохирлын хэмжээ;

- Гэмт хэрэгт холбогдсон хүмүүс, тэдгээрийн онцлог;

- Хэргийн хөдөлгөөн, шийдвэрлэлт /түдгэлзүүлэсэн гэмт хэрэг, шийдвэрлэл/;

- Захиргааны зөрчил, баривчлагдсан, эрүүлжүүлэгдсэн, захиргааны хяналтанд байгаа хүмүүсийн талаарх тоон мэдээллүүдийг зайлшгүй тусгасан байх шаардлагатай.

Эцэст нь гэмт хэргийн шалтгаан нөхцөл, түүнд нөлөөлж буй хүчин зүйлсийг бүх талаас нь судалж оновчтой тодорхойлсон, бодитой үнэлэлт дүгнэлт өгч чадсан судалгааг хийж чадаж байж гэмт хэрэгтэй тэмцэх бодлого боловсруулагдаж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх таслан зогсоо практик арга хэмжээнүүд зохион байгуулагдаж байх ёстой.

Хариуцсан нутаг дэвсгэр, салбарын хэмжээний гэмт хэргийн нөхцөл байдалд судалгаа, дүн шинжилгээ хийх, шалтгаан нөхцлийг бодитой тодорхойлох ажилд анхаарч, шинэлэг санаа, идэвх гарган ажиллах нь үйлдэгдсэн гэмт хэргийг илрүүлэхээс илүүтэй үр дүнтэй ач холбогдолтой ажил гэдгийг ойлгож, мэдэрч ажиллах нь цагдаагийн алба хаагчид тавигдах нэг гол шалгуур ч байж болох юм.



Судалгаанаас үзэхдээ нийслэл хотод иргэдийн аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий Нийслэлийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлэгч агентлаг 32 байгууллага² ажиллаж байгаа ба Хэвлэлийн хүрээлэнгийн мониторингийн дүнгээр өнөөдрийн байдлаар Монгол Улсын хэмжээнд нийт 430 хэвлэл мэдээллийн байгууллага үйл ажиллагаагаа тогтвортой явуулж байгаагаас 386 нь буюу 90 хувь нь мониторингийн судалгаанд оролцож, байгууллагынхаа тухай мэдээллээ ирүүлсэн юм.

Иргэдийн мэдээллийн эх сурвалж өнөөдөр сонин, сэтгүүл, радио, телевизээр тогтохгүй интернет сонин, цахим карт, тэр байтугай ярьдаг гар утаснаасаа мэдээлэл авдаг болсоноор мэдээллийн эх үүсвэрүүд хязгаартгүй мэт болж байна. Эдгээрийн нэгэнд сүүлийн жилүүдэд хүч түрэн орж ирсэн нь FM радио болж байна. Тиймээс хүмүүс радио их сонсож байна уу аль эсвэл телевиз их үзэж байна уу гэсэн асуултанд шууд телевиз гэж хариуулж болохгүй нь. Гэхдээ судалгаагаар иргэдийн 90 хувь нь дотоодын мэдээлэл авдаг гол эх сурвалж, мэдээллийн хэрэгслээр телевизийг нэрлэжээ. Удаад нь 40,7 хувиар сонин, харин радио 28,9 хувиар гуравт орсон байна. Гэхдээ энд радиог дотор нь үндэсний, орон нутгийн, нийслэл доторхи, Fm гэх мэтээр ялгаатай хандвал Fm нь телевизээс дутахгүй хүмүүсийг эзэмддэг мэдээллийн хэрэгслээр тодроод байгаа аж. Ямартай ч Хэвлэлийн Хүрээлэн бидний мэдээллийн өргөнцөд хүч түрэн орж ирсэн FM-үүдийн талаар анх удаа судалгаа хийсэн байна³. Өнөөдөр манай улсад 44 радио ажиллаж, 37 телевиз үйл ажиллагаа явуулж байгаагийн 15 нь кабелын

телевиз байна. Энэ оны байдлаар Монголд 44 богино долгионы болон өргөн нэвтрүүлгийн радио станц ажиллаж байгаагийн 43 нь радио, үүний 24 нь орон нутагт, 19 нь нийслэлд ажиллаж байна. Улаанбаатар хотод цацагдаж буй радионуудын 16 нь хувийнх, 3 нь төрийн байгууллагынх аж. Орон нутгийн радионууд 7 хоногт дунджаар 1522,6 цагийн хөтөлбөр хүргэдэг бол нийслэлийн радионууд мөн 7 хоногт дундажаас 1848 цагийн нэвтрүүлэг цацдаг аж. Ингээд хамгийн их сонсогчтой радиогоор судалгаандорлцогчдын 27,1 хувь нь “УБ радио 101,7”, 20 хувь нь “Элгэн нутаг 100.1”, 17.4 хувь нь “Шинэ долгион 107.5”, “Эх орон-залуусын 102.1 радио”, “Миний Монгол 100.5” радио оржээ. Энэ онд шинээр 98.1, 99.3, 99.7, 99.9 гэсэн 4 радио үйл ажиллагаа явуулж эхэлсэн. Үүнээс “Инээмсэглэл” 99.3 радио сонсогчдын тоогоор дээгүүр орсон нь сонсогчдын сонирхлыг татах чанартай нэвтрүүлэг бэлтгэх нь сонсогчдын дунд тухайн радиогийн рейтинг өсөхөд чухал түлхэц бодлог байна.

Уlamжлалт мэдээллийн хэрэгслийн ашиглалт буурах хандлагатай болж интернэтийн хэрэглээ өссөн судалгааны дүнг гарлаа. Интернэт тогтмол хэрэглэгчийн тоо 30 хувьд хүрч хамгийн хүртээмжтэй мэдээллийн хэрэгсэл телевизийн араас орж буй нь иргэд сонин үншиж, радио сонсохоос илүү интернэтийг ашиглах нь түгээмэл болсныг харуулав. 2007 оноос хойш интернэт хэрэглэгчийн тоо 2.5 дахин өсчээ. Үүнийг хот, хөдөөгөөр ялган харуулбал, интернэт хэрэглэгчийн тоо 2007 онд хотод 11 хувьтай, хөдөө 9.3 хувьтай байсан бол 2009 онд хотод 35 хувь, хөдөө 26 хувь болж өсчээ. Мөн иргэдийн мэдээлэл авдаг хамгийн гол эх сурвалжид интернэт нэмэгдэж радиогоос

мэдээлэл авах нь буурсан байна.⁴

Хэвлэл мэдээлэл нь санаатайгаар эсвэл хайхрамжгүйгээс болж ялгаварлан гадуурхах, хүч хэрэглэх үзлийг хөөрөгдвэл ноцтой аюул үүсж болно гэдгийг байнга ухамсарлаж ажиллах ёстой. Хэвлэл мэдээлэл нь энэ аюулыг ухамсарлаж буй бол гарал угсаа, яс үндэс, харьяалал, арьс өнгө, шашин шүтлэг, хүйс, болон өөр бусад шалтгаан, үзэн ядалт, эсвэл тэгш бус байдлыг дэмжих буюу хөөрөгдөхгүй тулд чадах бүхнээ хийж ямар ч нөхцөл байдалд хэвлэл мэдээлэл нь гэмт хэрэг, хучирхийлэлд турхирч болох мэдээллийг гаргахгүй байхшаардлагатай байна. Тухайлбал, 2012 оны 09 сарын 16-ны өдрийн нэгэн мэдээлэлд анхаарлаа хандуулахад Ц.Мөнхбаяр тэргүүтэй этгээдүүд нь төрийн ордонд зэвсэглэн халдсан талаарх мэдээллийг газар дээрээс нь шууд сурвалжлан улс орон даяар олон төлвиз, хэвлэл мэдээллийн хэрэгслээр нэвтрүүлсэн. Тухайн үед гэмт этгээд нь гар утасаар бид нар одоо эхэллээ. Та нар бэлэн байгаарай хэмээн ярьж байгаа бичлэгийг гаргасан нь иргэдийг гэмт хэрэгт турхирч 2008.07.01-нд болсон нийтийг хамарсан эмх замbaraагүй байдалд хүргэсэн бол хэнийг ахин буруутгах бэ? Уг тохиолдолд тухайн этгээдийн дууг хааж, зөвхөн дурсийг харуулан нэвтрүүлж болох боломж байсан. Үүнд сэтгүүлчийн мэдлэг боловсрол, сэтгэл зүй дутсан гэж үзэж байна.

Онцгой нөхцөл байдлын үеийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээллэгдэж буй мэдээлэл нь шийдвэр гаргагч буюу өндөр алба тушаалтнууд, ард иргэдэд үргэлж нөлөөлдөг гэдгийг сайн ойлгож байх ёстой. Онцгой нөхцөл байдал үссэн үед хэвлэл мэдээллийн ажилтнууд, тухайн үед ажиллаж

² Монгол Улсын Засгийн газрын 190-р тогтоол. www.legalinfo.mn

³ Chuhal medee.mn

⁴ “Судалгааны тайлангийн эмхтгэл” Хууль зүйн үндэсний хүрээлэн. 2012



НИЙСЛЭЛ ХОТ ДАХЬ ГЭМТ ЯВДЛЫН ЧИГ ХАНДЛАГА, УРҮДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ЗАМ



Б.Мөнхордж

ХСИС-ийн ШУТГ-ын Эрдэм шинжилгээний ахлах ажилтан,
докторант, цагдаагийн ахмад

Нийслэлийн хүн амын ачааллыг дээрх суурин хүн амын тоон үзүүлэлтээр үзэж болох ч их, дээд сургуульд суралцагчид (175000 /үүний 100,000 хөдөө орон нутгийнх), шилжин ирэгсэд (30 000, 2004 онд 68808), шинээр

руу чиглэсэн хөдөлгөөн ихэссэн, хөдөө орон нутгаас шилжин ирэгсэд суурьшиж, төлөвшөөгүй байдлаас болж гэмт хэргийн гаралт их байна. Монгол Улсын хувьд “Улаанбаатар хот гэмт хэргийн үнэмлэхүй төв” болж байна.

Нийслэл хот дахь гэмт явдлын нөхцөл байдал, чиг хандлага буюу хэтийн төлөвийг тооцоолж, төрийн байгууллагуудын гэмт явдлаас урьдчилан сэргийлэх чиглэлээр хамтын ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгч, цаашид урьдчилан сэргийлэх арга замын талаар санал дэвшүүллээ.

Нэг. Нийслэл хот дахь гэмт явдлын нөхцөл байдал ямар байна вэ?


Монгол Улсын нийслэл Улаанбаатар хот нийгэм, эдийн засаг, дэд бүтцийн хувьд хөгжихийн зэрэгцээ хотын хүн ам 1990 оноос хойш 2.4 дахин өсчээ. 2010-2013 оны дундаж өсөлт 3.5 хувьтай¹ байна. Иймээс хүн амын өсөлтийг дагаад нийгмийн эерэг, сөрөг үзэгдэл явагдаж байна. Өөрөөр хэлбэл, гэмт явдлын шалтгаан, нөхцлийн нэг гол хүчин зүйл бол хүн амын төвлөрөл нягтрал болж байна.

Төрж буй хүүхэд (33 000), суурин хүн амаар улсын хэмжээний хүн амын 46 хувь нийслэлд амьдарч байна гэх боловч, Нийслэлд Монгол Улсын хүн амын ойролцоогоор 52 ба түүнээс хувь нь амьдарч, ажиллаж, сурч байна. 2010 оны хүн амын тооллогоор 63 хувь нь амьдарч буй дүн гарсан байdag.

Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотод бүртгэгдсэн гэмт хэргийн эзлэх хувийн жин 2012 онд 58.4 хувь² байжээ. Энэ үзүүлэлт цаашид өсөх хандлагатай байна. Хүн амын төвлөрөл, нийгэм, эдийн засаг, дэд бүтцээ дагаад хот


Нийслэл хотод гэмт хэргийн тархалтыг дүүргээр ангилан 2012 оны байдлаар үзүүлбэл хамгийн их буюу 21.2 хувь нь Баянзүрх, 18.4 хувь нь Баянгол, 16.5 хувь нь Сонгинохайрхан, 16.3 хувь нь Сүхбаатар дүүрэгт үйлдэгджээ. Баянзүрх дүүргийн тухайд хамрах нутаг дэвсгэр том, хүн ам ихтэй, Нарантуул, Техникийн зах, худалдааны төвүүд үйл ажиллагаа явуулдаг, Баянгол дүүрэг хотын төв дүүрэг, худалдаа, үйлчилгээний аж ахуйн нэгжүүд, хүн ам төвлөрсөн онцлогтой дүүрэг юм. Сонгинохайрхан дүүргийн тухайд хүн ам ихтэй, газар нутгийн хэмжээ том, гэр хорооллын гудамж талбай, амралтын газар, зуслан ихтэй байдал нөлөөлсөн байх талтай.

Улаанбаатар хотын шинэ удирдлагаас гэмт явдлаас урьдчилан сэргийлэх байдлаар хязгаарлах бус, бүр иргэдийнхээ аюулгүй байдлыг хангах, амар тайван амьдрах нөхцөл бүрдүүлэхэд ихээхэн анхаарч байгаа билээ. Нийслэлийн ард иргэдийн аюулгүй байдлыг




¹ ЦЕГ-ын Мэдээлэл, судалгааны төвөөс гаргасан статистикийн мэдээллээр

² <http://ubstat.mn/Statistics>



тооцож үзвэл 2016 онд 1512.6 болж өсөх, улмаар Үндэсний статистикийн хорооны хийсэн хэтийн тооцоогоор 2020 онд 1700.9, 2030 онд 2161.7 мянган хүн амтай болох тооцоотой байна.

Нийслэл хот дахь гэмт явдлын хөдөлгөөн, динамикийг авч үзвэл 2001 оноос 2012 он хүртэл өсөх хандлагатай байжээ. 2001 оноос 2012 он хүртэл жилд дунджаар 222 гэмт хэргээр өсчээ.



Хүн амын өсөлт, гэмт явдлын хөдөлгөөн, динамик хооронд шууд хамааралтай буюу математик статистикийн талаас шулзуун шугаман хамааралтай байгаа учраас шулзуун шугаман регрессийн аргаар гэмт явдлын хэтийн төлөвийг тооцоольё.



асуудалч мөн хамаарна. Аюулгүй байдлыг хангах буюу Гэмт явдлаас урьдчилан сэргийлэхажилд оролцох төрийн байгууллагууд, тодруулбал, Нийслэлийн Иргэдийн тэргүүлэгчдийн хурал, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, түүний харьяа алба, хэлтэс, Шүүх, Прокурор, Цагдаа, Тагнуул, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх, Онцгой байдал, Эрүүл мэнд, Боловсрол, Соёл, хэвлэл, мэдээллийн байгууллагууд оролцох үүрэгтэй.

Хууль зүйн салбарын шинэтгэлийн хүрээнд Цагдаагийн албаны тухай, Тахарын албан тухай хууль батлагдсан, одоо Гэмт хэргийн тухай, Зөрчлийн тухай, Гэмт хэргийг хянан шийдвэрлэх тухай, Хууль сахиулах үйл ажиллагааны тухай, Мөрдөх албаны тухай, Архидан согтууралтай тэмцэх, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хуулийн төсөл хэлэлцэгдэж батлагдах гэж байна. Үүнтэй уялдаад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийг шинэчлэх ажлын хэсэг ажиллаж байна. Эдгээр хуулийн шинэчлэлийн үзэл баримтлалд нийслэлийн гэмт явдлаас урьдчилан сэргийлэх талаар бодлогын шинжтэй санал тусгаж өгөх нь зүйтэй.

Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр, төлөвлөгөө болон Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2013-2016 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам хамгаалах, урьдчилан сэргийлэх, иргэд аюулгүй, амгалан амьдрах нөхцөлийг хангах тодорхой ажлууд туссан, үүнийг ажил хэрэг болгох нь зүйтэй.

Дөрөв. Санал, зөвлөмж

1. Шинэчлэлийн Засгийн газрын хөтөлбөр, төлөвлөгөө, Улаанбаатар хотын Засаг даргын мөрийн хөтөлбөр, хууль зүйн салбарын шинэтгэлтэй уялдуулан Нийслэлийн хэмжээний “Аюулгүй

байдлыг 2014-2016 онд хангах стратеги төлөвлөгөө” гаргаж, хэрэгжүүлэх. Учир нь харьяа байгууллага, дүүргийн зохицуулах зөвлөлүүд тус тусдаа төлөвлөгөө гарган, урьдчилан сэргийлэх ажлыг өөр өөрсдийн чиг үүргээ хэрэгжүүлэх байдлаар, нэгдсэн бодлого, төлөвлөлтгүйгээр явуулж байна гэхэд илүүдэхгүй болов уу. Үүнд:

- Гэмт явдлын шалтгаан, нөхцлийн тэргүүлэх чиглэлээ тодорхойлох. (*Хулгайлах, танхайрах, зам тээврийн осол, хар тамхи, биеэ үнэлэлт, гэр булийн хүчирхийлэл, архидан согтуурал, хуүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хүнсний аюулгүй байдал, амьдрах барилга, байгууламж гэх мэт)*)

• Бүх төрийн байгууллагуудын оролцоог нарийн тусгаж өгөх, үүрэг оролцоог нарийвчлан оруулах, тухайлбал, шүүх, цагдаа, прокурор, мэргэжлийн хяналт, онцгой байдал гэх ямар ажил хийхийг тодорхойлох.

• Иргэний бүртгэлийн байгууллага, хороод хүн амын судалгааг сайн хийдэг, сан бүрдүүлдэг байх. Учир нь хорооны хэсгийн ахлагч нар хүнээ бүрэн бүртгэхгүйгээс гэмт хэрэг илрүүлэх, таслан зогсоох, урьдчилан сэргийлэхэд хүндрэл үүсч байна.

• Нийслэлийн хэмжээнд гэмт явдлаас урьдчилан сэргийлэх ажилд хууль зүйн салбарын их, дээд сургууль, хүрээлэн, судалгааны төвүүдийн хамтын ажиллагааг өргөжүүлж, тэдний дэмжлэг, хүчийг авч ажиллах.

2. Шинэчлэлийн Засгийн газар, нийслэлийн Засаг даргын мөрийн хөтөлбөр хэрэгжих хугацаанд буюу 2016 он хүртэл гэмт хэргийн гаралт тоон үзүүлэлтээр есөх нь ойлгомжтой. Иймд үйл ажиллагаандаа ахиц, үр дүн гаргасан гэх чанарын үзүүлэлттэй болох нь зүйтэй. Аюулгүй байдлыг илэрхийлэх шалгуур үзүүлэлтийг

нарийвчлан гаргаж, 2016 онд хүрсэн үр дүнгээ үнэлэх /Гэмт хэргийн тоо өснө, 1000 хүн амд ногдох гэмт хэргээ бууруулсан эсэхийг үнэлэх асуудал давхар авч үзэх/

3. Гэмт явдлаас урьдчилан сэргийлэх эрх зүйн орчныг сайжруулж, үйл ажиллагааг нь тогтмолжуулах, байгууллагууд үүрэг хариуцлагыг өндөржүүлэх.

• Төрийн байгууллага бүрт гэмт явдлаас урьдчилан сэргийлэх ажил хариуцсан ажилтантай болгох.

• Мэдээлэл байнга солилцох, нэгдсэн сүлжээтэй болох.

• Улаанбаатар хотын цахим хуудсанд “**аюулгүй байдлыг хангах**” чиглэлээр булан ажиллуулах.

• Аюулгүй байдлыг хангах, гэмт явдлаас урьдчилан сэргийлэх чиглэлээр үүрэн телефоны оператор компаниудтай (Mobicom, Skytel, Unitel, Gmobile гэх мэт), түүнчлэн хэвлэл мэдээллийн байгууллагатай нягт хамтран ажиллах.

4. Нийслэлийн дэд бүтэц, төлөвлөлт, хөгжлийн асуудалд гэмт явдлаас урьдчилан сэргийлэх асуудлыг заавал авч үзэх байх. Гэр хорооллын дахин төлөвлөлттэй уялдуулан “хаягжуулалт” төсөл хэрэгжүүлэх, “Гэрэлтэй Улаанбаатар” болох гэх мэт. Тухайлбал, төвлөрсөн захуудыг өөрчлөн байгуулах, орон сууцны хоткон барьж байгуулах, метро байгуулах асуудал дээр аюулгүй байдлыг тооцоолох нь зүйтэй. Эдгээр дэд бүтцийн томоохон төсөл, хөтөлбөрт ажлыг шинжлэх ухааны байгууллагатай хамтран хэрэгжүүлэх.


5. Аюулгүй байдлыг хангахад шинэ технологи, техник хэрэгсэл нэвтрүүлэх. Нэгдсэн⁵ байдлаар камержуулах, compstat, CCTV нэвтрүүлэх, crime mapping нэвтрүүлэх зэрэг болно.

⁵Камержуулалт тус тусдаа явагдаж байна.



Авлигатай тэмцэх газар нь² Эрүүгийн хуулийн тусгай ангийн 263³, 264⁴, 265⁵, 266⁶, 268⁷, 269⁸, 270⁹, 270¹⁰ дүгээр зүйл, 273¹⁰ дугаар зүйлд заасан гэмт хэргийг харьялан шалгадаг. 2007-2013 онд нийт 2344 холбогдгчтой 1083 эрүүгийн хэрэг шалгажээ.


АТГ-аас шалгасан эрүүгийн хэрэг



2007-2013 онд Мөрдөн байцаалт явуулсан эрүүгийн хэргүүдээс 287 буюу 26.5 хувийг яллах дүгнэлт үйлдүүлэхээр, 235 буюу 21.7 хувийг хэрэгсэхгүй болгох саналтайгаар, 186 буюу 17.2 хувийг харьяаллын дагуу шилжүүлж, 101 буюу 9.3 хувийг өөр эрүүгийн хэрэгт нэгтгэж, 44 буюу 4.1 хувийг ЭБШХ-ийн 205 дугаар зүйлийг үндэслэн түдгэлзүүлж шийдвэрлэсэн бөгөөд 232 буюу 21.4 хувь нь ажиллагаанд шалгагдаж байсан гэсэн статистик мэдээ гарчээ.

Эрүүгийн хэргийн шийдвэрлэлт 2007-2013 он

Авлигатай тэмцэх газар 2008-2013 онд **237** холбогдгчтой **103** эрүүгийн хэргийг шалгаж, шүүхээр



шийдвэрлүүлсэн байна.¹¹

²ЭБШХ-ийн 27 дугаар зүйлийн 27.3-д заалт

³/Төрийн албан тушаалтан, албаны эрх мэдлээ урвуулах/

⁴Төрийн албан тушаалтан, албаны эрх мэдлээ хэтрүүлэх

⁵Төрийн бус байгууллагын албан тушаалын байдлаа урвуулах

⁶Төрийн бус байгууллагын албан тушаалын байдлаа хэтрүүлэх

⁷Хээл хахууль авах


⁸хээл хахууль өгөх

⁹Хээл хахуульд зуучлах

¹⁰Төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах

¹¹ АТГ-ын мэдээллээр

ХУУЛЬ БУСААР ХӨРӨНГӨЖИХ ГЭМТ ХЭРГИЙН ШАЛТГААН НӨХЦӨЛ, УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЗАРИМ АСУУДАЛ




АТГ-аас ЭБШХ-ийн 26, 27 дугаар зүйлд заасан харьяаллын дагуу дээрх эрүүгийн хэргийг шалгажээ.

АТГ-аас шалгасан эрүүгийн хэрэг, Бүртгэгдсэн¹² Албан тушаалын гэмт хэргийн харьцуулалт

Улсад бүртгэгдсэн гэмт хэргийн тоо бүртгэлийн заавар”-ын дагуу Монгол Улсад бүртгэгдсэн албан тушаалын гэмт хэргийг ЦЕГ-ын Мэдээлэл судалгааны төв дээр нэгтгэн төвлөрүүлж, улсын хэмжээний статистик мэдээ гардаг. Бүртгэгдсэн гэмт хэрэг, шалгасан

тоо бүртгэлд оруулах, улмаар Үндэсний статистикийн хороонд хүргэгддэг, улсын хэмжээний албан ёсны статистик мэдээнд тусдаг юм.

ҮДШ-ийн Судалгааны төвийн мэдээллээр (2013 оны мэдээлэл Шүүхийн ерөнхий



Үндэсний статистикийн хорооноос зөвшөөрсөний дагуу ХЗДХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2010.01.01-ний өдрийн 01 тоот тушаалаар батлагдсан “Гэмт хэргийн тоо бүртгэлийн маягт, гэмт хэргийн статистик мэдээний маягт”, “Гэмт хэргийн тоо бүртгэлийн маягт нөхөх, мэдээллийн санд оруулах журам” мөрдөгдж байна. Энэхүү журмаар АТГ, ТЕГ, УЕП-ын дэргэдэх Мөрдөн байцаах албанда шалгагдаж буй эрүүгийн хэргийг Монгол Улсын хэмжээний гэмт хэргийн

¹²ЦЕГ-ын Мэдээлэл, судалгааны төвийн мэдээллээр

эрүүгийн хэрэг зарчмын хувьд зөрүүтэй гарч болно.

Учир нь АТГ, ТЕГ, ЦЕГ, УЕП-ын дэргэдэх Мөрдөн байцаах албаны даргын хамтарсан 2010.04.28-ны 43/223/82/21 тоот тушаалаар баталсан “Гэмт хэргийн тоо бүртгэлийн маягтыг нөхөх, мэдээллийн санд оруулах журам” мөрдөгдж байна. Энэхүү журмаар АТГ, ТЕГ, УЕП-ын дэргэдэх Мөрдөн байцаах албанда шалгагдаж буй эрүүгийн хэргийг Монгол Улсын хэмжээний гэмт хэргийн

зөвлөлийн мэдээллээр) авлига, албан тушаалын анхан шатны шүүхээр шийдвэрлэгдсэн байдлыг авч үзье. Доорх графикаас хараад авлига, албан тушаалын гэмт хэргийн шүүхээр шийдвэрлэлт нэмэгдэх хандлага байна.

2013 онд яллах дүгнэлт үйлдүүлэхээр шилжүүлсэн 33 шүүгдэгчид холбогдох 11 хэргэ шүүхээр шийдвэрлэгдэж, 26 шүүгдэгчийг гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцон 12 шүүгдэгчийг хорих ялаар,



ажлын уялдаа холбоо сул

Б. Хувь хүнээс үүдэлтэй шалтгаан, нөхцөл

- Төрийн албан хаагчдын ашиг сонирхлын зөрчил
- Хууль, эрх зүйн мэдлэг сул байдал

• Улс төр, бизнесийн хүрээний нөлөөлэлд автах, албаны эрх мэдлээ урвуулах, хэтрүүлэх

• Төрийн албаны сонгон шалгаруулалт, томилгооны дутагдал

• Төрийн албан хаагчдын ёс зүйгүй байдал

Авлигын индексийн судалгааны Шинжээчдийн болон Олон нийтийн төсөөллийн судалгаанд оролцогч шинжээч, иргэд, төрийн албан хаагч, бизнес эрхлэгчдээс Монгол Улсад авлига үүсгэж буй шалтгаан нөхцөлийг асуухад дараах шалтгаануудыг гол шалтгаан гэж нэрлэсэн байна¹⁴. **Авлигын шалтгаан нөхцөл, шинжээчдийн болон олон нийтийн төсөөллийн судалгаа /хамгийн их нэрлэсэн шалтгаан нөхцөлөр/**

хаагчдын цалин, орлого бага, эрх зүйн зохицуулалт, хуулийн хэрэгжилт сул байгаа нь Монгол Улсад авлига үүсэхэд хамгийн ихээр нөлөөлж буй гол шалтгаан гэж дүгнэж болохоор байна.

Түүнчлэн шинжээч, төрийн албан хаагч, бизнес эрхлэгчдийн үзэж байгаагаар хүмүүсийн сэтгэлгээ, ухамсын түвшин муу, ёс зүйгүй байдал нь авлига үүсэх шалтгааны бас нэг гол нөхцөл болохыг харууллаа. Авлига үүсэхэд хамгийн ихээр нөлөөлж буй шалтгааныг шинжээчид хариуцлага тооцдоггүй, хөндлөнгийн хяналт сул явдал гэж дүгнэсэн байхад харин иргэд, төрийн албан хаагчид ажилгүйдэл болон ядуурал, бизнес эрхлэгчид төрийн үйлчилгээний хүртээмж муу байгаа нь авлига үүсэх шалтгаан болж байна гэж үзсэн байна

Хууль бусаар хөрөнгөжих гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зарим асуудал: Монгол Улс авлигын эсрэг

авлигатай тэмцэж байгаа нь нэн чухал юм. Ялангуяа конвенцийн заалт, цаг усийн шаардлагаар хууль бусаар хөрөнгөжихийг гэмт хэрэгт тооцох замаар авлигатай чанга бодлооор тэмцэх гэж буй нь бүр ч сайшаалтай байна.

Албан тушаал, түүний дотор хууль бусаар хөрөнгөжих гэмт хэргээс доор байдлаар урьдчилан сэргийлэх нь зүйтэй гэж үзэж байна. Уүнд:

- Авлигын эсрэг конвенцийг бүрэн хэрэгжүүлэх, үндэсний хууль тогтоомжоо нийцүүлэх;

- Авлигатай тэмцэх үндэсний стратегийг баталж, мөрдүүлэх;

- Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлыг улсын хэмжээнд өргөн далайттай зохион байгуулах;

- Монгол Улсад шударга ёсиг тогтоох үйл хэргийг төрийн болон хувийн хэвшлийн бүх шатанд хэрэгжүүлэх;

- Авлига, хүнд суртал, ил тод байдлын талаар олон улсын

Шинжээч	Иргэд	Төрийн албан хаагч	Бизнес эрхлэгч
Улс төрийн нөлөө их	Улс төрийн нөлөө их	Улс төрийн нөлөө их	Улс төрийн нөлөө их
Ашиг сонирхлын зөрчил их	Ашиг сонирхлын зөрчил их	Ашиг сонирхлын зөрчил их	Ашиг сонирхлын зөрчил их
Төрийн албан хаагчдын цалин, орлого бага	Цалин, орлого бага	Төрийн албан хаагчдын цалин, орлого бага	Цалин, орлого бага
Эрх зүйн зохицуулалт, хуулийн хэрэгжилт сул	Эрх зүйн зохицуулалт, хуулийн хэрэгжилт сул	Эрх зүйн зохицуулалт, хуулийн хэрэгжилт сул	Эрх зүйн зохицуулалт, хуулийн хэрэгжилт сул
Хүмүүсийн сэтгэлгээ, ухамсын түвшин муу, ёс зүйгүй байдал	Ажлаа хурдан бүтээхийн тулд	Хүмүүсийн сэтгэлгээ, ухамсын түвшин муу, ёс зүйгүй байдал	Хүмүүсийн сэтгэлгээ, ухамсын түвшин муу, ёс зүйгүй байдал
Хариуцлага тооц-доггүй, хөндлөнгийн хяналт сул	Ажилгүйдэл, ядуурал	Ажилгүйдэл, ядуурал	Төрийн үйлчилгээний хүртээмж муу

Шинжээч, иргэд, төрийн албан хаагч, бизнес эрхлэгчдийн үзсэнээр улс төрийн нөлөө их, ашиг сонирхлын зөрчил үүсэх магадлал өндөр, төрийн албан

конвенцид нэгдэн орж, соёрхон баталсан, улмаар авлигын эсрэг хууль, тусгайлан байгууллага байгуулж, нийтийн болон хувийн ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль гарган, аливаа олон талт хэлбэрээр

болон дотоодын олон нийтийн байгууллагын судалгаа, авлигын индексийн судалгаанд үндэслэн урьдчилан сэргийлэх зорилтод үйл ажиллагааг төлөвлөн, хэрэгжүүлэх;

- Төрийн алба хаагчдын хувийн

¹⁴Авлигын индексийн 2013 оны судалгааны тайлан, www.iaac.mn



татдаг юм. Их засаг хуулийн судлалд үнэтэй хувь нэмэр оруулсан гадаадын эрдэмтдээс дурдвал: Египетийн түүхч Макризм, Ираны нэрт түүхч Жувейн, Рашид-Ад-Дин, ОХУ-ын түүхч Владимирцов Б.Я.Рязановский В.А., Хятадын Өвөр Монголын өөртөө засах орны Сайшаал, Найралт, Японы Мураками М. АНУ-ын Вернадский.Ж (George V.VERNADSKY), Их Британий Ральф Фокс, Францын Морис Пержерон зэрэг, мөн Монголын нэрт түүхчид болох Нацагдорж.Ш, Ишжамц.Н, Пэрлээ.Х, Жугдэр.Ч, Далай.Ч, Бираа.Ш, мөн хуульч эрдэмтэд болох Совд.Г.Авирамд.Э, Дашиам.И, Дащцэдэн.Д, Ням-Осор.Н нар Их Засаг хууль судлалын хөгжилд үнэтгэй хувь нэмэр оруулжээ.

Олон эрдэмтэн судлаачдын санал нэг үзэж буйгаар Их Засаг хуулийг 1206 онд хаад, ноёдын Их хуралдайгаар¹ хэлэлцэж баталж, 1260 он хүртэл Монголын их хаадын үед тогтвортой үйлчилж, цаашид ч Их Засаг хуулийн залгамж баттай хадгалагдан үргэлжилж байжээ.

Их Засаг хуулийн бүрэн эх бичвэр өнөөг хүртэл билэнд олдоогүй байгаа нь уг хуулийн судлалд болон бидний уг хууль дахь байгаль хамгаалал, ашигт малтмалын холбогдолтой хэм хэмжээний судлалд ч бэрхшээл учруулж байна. Тиймээс бид энэхүү судалгааны ажилдаа дээрх эрдэмтдийн нийтлүүлсэн Их Засаг хуулийн «хуулбар» хувилбараас ишлэл хийн судалсныг судалгаандаа ашигласныг дурьдвал зохилтой. Мөн уг хуульд байгаль орчныг хамгаалах талаар олон сонирхолтой заалтууд тусгагдсан ч судлаачийн зүгээс зөвхөн ашигт малтмал, газрын хэвллийг хамгаалах талаар хуульчилсан

¹Их хуралдай гэж Монголын хаан, түүний төрт хатгад, шадар ноёд, тайж, түшмэдүүдээс бүрдсэн эзэнт гүрний том чуулган бөгөөд уг харалдайгаар Монголын төрийн томоохон асуудлыг холццэж, ардчилсан зарчмаар санал хурааж шийддэг байжээ.

хэсгийг онцлог дурдахыг зорилгоо болголоо.

Их Засаг хууль нь байгаль орчны талаар Монголчуудын зан заншлын уламжлалаас дийлэнхийг нь хуульчилж өгсөн нь тодорхой юм. Энэ талаар хууль зүйн ухааны доктор, профессор Г.Баярхүү: «Их Засаг бол Монголчуудын зан заншлын хамгийн нийтлэг хэв зуршлыг хуульчилж, зан заншил, ёс суртахууны охь шилдэг бүхнийг төрийн зүгээс ёс зүй болон эрх зүйн хэм хэмжээнд оруулан хуульчилж, амьдралд хэрэгжүүлж чадсан»² хэмээн дүгнэлт хийсэнтэй санал нэг байна. Гэхдээ Их Засаг хууль нь дан ганц зан заншлын хэм хэмжээний цуглгуулга биш эзэнт гүрний засаглал, Чингис хааны зарлиг болон Их Хуралдайн шийдвэр зэргээс бүрдсэн цогц кодекс байсан гэдгийг онцлон тэмдэглэмээр байна. Их Засаг хууль нь бүтцийн хувьд Чингис хааны зарлиг, Чингис хааны засаг, Чингис хааны билиг сургааль гэсэн 3 хэсгээс бүрдэнэ³ гэж манай зарим эрдэмтэд нэгтгэн дүгнэжээ. Чингис хааны засаг⁴ хэмээх хэсэгт: «Газар дээр сүү болон бусад цагаан идээний зүйл асгаж болохгүй»⁵ гэж заасан нь газар нутаг, хөрөнгө шороо, бэлчээрийг доройтолд хүргэхгүй, хөрөнгөй бохирдуулахгүй байх эрх зүйн үндсийг анх бий болгосон, энэ утгаараа байгаль хамгаалах өргөн хүрээтэй асуудлын дотроос юуны түрүүнд газрын тухай асуудлыг эн тэргүүний гэж үзэн хууль зүйн үндсийг нь ийнхүү анх тавьж өгчээ. Тийм ч учраас энэхүү Чингис хааны засаг одоогийн

²Баярхүү. Г. Монголын нэгдсэн төрийн болон дараа үеийн хууль цааз заншлын хэм хэмжээг харьцуулан судалсан нь (XIII-XVIII зуун). УБ., 1997. С.15.

³Комментарии Чингис хааны Их засаг хууль. Хамтын бүтээл: Дащцэдэн.Д, Авирамд.Э., Совд.Г., Нямбуу.Х. Улаанбаатар, 1997. С. 21.

⁴Засаг гэдэг нь хууль гэсэн утгатай бөгөөд тид тодорхой үйлдлүүдийг хориглож, зорчвол оногдуулах шийтгэлийн хэмжээг шууд тогтоож огсон байдаг.

⁵Дашиам. И. Чингис хааны Их Засаг хууль. УБ., 1995. С. 27.

Монгол Улсын Газрын тухай⁶ хуулийн анхны эх үүсвэр болж өгсөн гэж үзэж болохоор байна.

Судлаачдын үзэж буйгаар Их засаг хуульд 1210, 1218 онуудад 2 удаа нэмэлт өөрчлөлт хийгдсэн гэж үздэг бөгөөд энэхүү нэмэлт, өөрчлөлт нь мөн л эх бичвэрээрээ бидэнд олдоогүй байгаа нь уг хуулийн судлалыг цаашид үргэлжлүүлэн түнзгийрүүлэн хийхийн чухлыг давхар илтгэж байна. Их засаг хуульд байгаль хамгаалах асуудлаар олон хэм хэмжээг тусгаж өгсөн нь энэ хуулийн үйлчлэлийн хугацаанд төдийгүй Монголын төрийн дараа дараагийн үеийн хууль цаазад залгамж чанараа хадгалж, хуулчлагдан ирсэн нь Монгол-Ойрадын хуулиас харагддаг.

XVII зууны эхэн үед монголын төр тогтвортгуй болж, баруун, зүүн монголчууд хоорондоо тэмцэлдэж, энэ цаг үед буюу 1640 онд баруун, зүүн Монголын ноёдын чуулган болж Монгол-Ойрадын хуулийг баталжээ. Уг хуулийн эх бидэнд өвлөгдөн ирсэн тодийгүй олон улс оронд тус туслын хэлээр орчуулан хэвлэж байсан баримт байна. Тухайлбал, 1879 онд Герман хэлээр, 1880 онд Орос хэлээр, 1931 онд Япон хэлээр хэвлэгдэж байжээ⁷. Энэ хууль нь монголын төр, тусгаар тогтнолыг хамгаалж бэхжүүлэхэд зориулагдсан эрх зүйн хэм хэмжээг нийгмийн амьдралын олон талт харилцааны хүрээнд тогтоон хэрэгжүүлэх гол бодлого барьсан хэдий ч байгаль орчныг хамгаалах асуудлыг ор тас орхиогүй байна. Энэ нь монголын төр гадаад, дотоод хүчин зүйлээсээ үлбаалан төрийн хямралтай байсан ч амьдралын орчин болсон байгаль орчныг хамгаалах асуудал нь улс гүрний тусгаар тогтнол, бүрэн

⁶ Монгол Улсын Газрын тухай цогц хууль анх 1942 онд батлагдаж, одоогийн хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль 2002 оны 06 дугаар сарын 07-ны өдөр батлагдсан.

⁷Амархуу. О. Байгаль орчныг хамгаалах Монгол зан заншил, хууль цааз /Уламжлал шинэчлэлийн асуудал/. Улан-Батор, 2000. С. 39.



нь Монгол улсад анх удаа ашигт малтмалын эрх зүйн зохицуулалт төдийгүй харьяа нутаг дэвсгэр дээрээ байгалийн баялагийг хамгаалах үүргийг тухайн нутаг дэвсгэрийн засаг түшмэдүүдэд биечлэн хариуцуулж, хариуцлага алдсан торийн албан тушаалтынг хатуу шийтгэл хулээлгэх талаар анх удаа тогтоож өгсөн хэм хэмжээ болсон юм. Дээрхи заалтууд нь амьдралд хэрэгжин биелсээр ирсэн зарим баримтыг энд дурдах нь судалгааны ажлын чухал ач холбогдолтой гэж үзэж байна. Тухайлбал, Монголд улсад анх XIX зууны сүүлчээр байгуулагдсан монгол оросын хамтарсан алтны уурхайг Богдын засгийн газар үргэлжлүүлэн ажиллуулах тухай гэрээг 1912 онд Оростой байгуулж, уг гэрээнд олборлосон нийт алтны 16.5 %-г алтаар нь буюу оросын рублээр монгол улсын санд нийлүүлж байхаар шийдвэрлэсэн байна¹⁵. Мөн оросын худалдаачдад алтны уурхай нээх эрх олгож гэрээ байгуулж байсан баримт ч байна¹⁶. Үүнтэй холбоотойгоор Богдын Засгийн газар 1913 онд «Монгол

¹⁵Архивын материал № 2-34-87.

¹⁶Улсын төв Архив. ТХ. №279.

улсын дотор алт, мөнгөний зэрэг олон зүйлийн уурхай нээх дүрэм»-ыг баталжээ. Эндээс дүгнэхэд энэ үед байгалийн баялагийг гадаадын иргэдэд концессын журмаар ашиглуулж байжээ.

Богдын Засгийн газраас байгаль орчныг хамгаалах чиглэлээр авч хэрэгжүүлсэн бас нэг томоохон арга хэмжээ бол 1916 онд Монгол улсын хөрөнгийг захирах газрыг тусгайлан байгуулсан явдал юм. Уг газрын дүрэмийн 19 дүгээр зүйлд: «Монгол улсын байгалийн бүх баялаг, ой мод, ус, элдэв уурхай ашиглаж байгаа болон ашиглаж болох сул газар бүгд Монгол улсын хөрөнгө мөн»¹⁷ гэж заажээ. Энэхүү заалт нь 1924 оны анхдугаар үндсэн хууль хүртэлх хугацаанд байгалийн баялагийн хувьд үндсэн хуулийн чанартай эрх зүйн хэм хэмжээ болж мөрдөгдсөн чухал баримт бичиг байжээ.

Улсын хөрөнгийг захирах газар нь (сангийн яам) монгол улсад анх удаа байгалийн бүх баялагийг бүртгэж, улсын хамгаалалтанд авах, түүнийг дотоод, гадаадын иргэдэд ашиглуулах ажлыг зохион

¹⁷Түүхийн хүрээлэнгийн гар бичмэлийн фонд. 7-р боть. С.235.

байгуулж, олсон орлогыг улсын санд тушаах, ашигт малтмалын боловсруулах үйлдвэр, үйл ажиллагаанд хяналт тавих зэрэг эрх, үүрэгтэй ажиллаж, байгалийн баялагийг хамгаалах төрийн бодлогыг хэрэгжүүлэгч тусгай эрх хэмжээтэй байгууллага байжээ. Энэхүү Зарлигаар тогтоосон монгол улсын хууль зүйлийн бичиг нь 1921 оны хувьсгал хүртэлх хугацаанд байгаль хамгаалах төрийн бодлого болон хэрэгжиж, түүний залгамж нь дараа дараагийн хууль тогтоомжуудад хуульчлагдан ирсэн юм.

Хувьсалаас өмнөх үеийн буюу 13 дугаар зуунаас 1921 он хүртэлх дурдан буй үеийн байгаль орчныг хамгаалах хууль цаазын төрийн бодлогыг товч дүгнэн хэлэхэд энэ цаг үеийн Монгол улс бол байгаль орчинд хандахдаа нүүдэлчдийн аж амьдралын зан заншил, соёл иргэншилийн хэм хэмжээг цаасан дээр буулган бичигдмэл хуулийг бүтгэн, уг хууль цаазын эх сурвалж нь цааш цаашдаа улам баяжин төгөлдөржиж байгаль орчныг хамгаалах асуудал тодорхой төрөл зүйлийн бие даасан харилцаа болон хуульчлагдаж, шинэ агуулгаар баяжуулж ирсэн байна.

ЦЭРЭГ ТАТЛАГААС ЗАЙЛСХИЙХ ГЭМТ ХЭРГИЙН ОЙЛГОЛТ, БҮРЭЛДЭХҮҮН, ЗҮЙЛЧЛЭЛИЙН ЗАРИМ АСУУДАЛ



Л.Бат-Очир
ХСИС-ийн Цагдаагийн сургуулийн Эрүүгийн эрх зүйн тэнхимиийн ахлах багши, цагдаагийн ахлах дэслэгч

оронч үзлийн дээд бахархал юм. Иргэд эх орноо батлан хамгаалах үйл хэрэгт шаардлагатай эд материалын болон сэтгэл санаа оюуны бүхий л зүйл хүч хөдөлмөрөө зориулах нь Монгол Улсын тусгаар тогтнол нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, гадаад аюулгүй байдлын үндсэн баталгаа байсаар байх болно. Хуулиар тогтоосон журмын дагуу цэргийн алба хаах үндсэн үүрэг нь¹ Монгол Улсын иргэн

бүрт хамааралтай ба цэргийн алба хаахтай холбогдох журмыг Цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд заасан бөгөөд Монгол Улсын иргэн үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтгэг, үзэл бодол, боловсрол ялгаварлахгүйгээр цэргийн алба хаах үүрэг хүлээнэ. Цэргийн алба нь төрийн албаны онцлог төрөл бөгөөд цэргийн жинхэнэ болон бэлтгэл албанаас

Эх орноо батлан хамгаалах, хуулийн дагуу цэргийн алба хаах явдал нь Монгол Улсын иргэн бүрийн үндэсний бахархал, эх

¹Монгол Улсын Үндсэн хууль. 1992. 17-р зүйлийн 4 дэх хэсэг



заасан.

1986 оны Эрүүгийн хуулийн 76-р зүйлд: Цэрэг татлагаас зайлсхийх гэмт хэргийг дээрх хуульд заасантай мөн адил хуульчилж зарим нэр томъёо, утгыг өөрчлөн найруулсан бөгөөд 77 дугаар зүйлд заасанцэргийн дайчилгааны татлагаас зайлсхийх гэмт хэргийг хүндруулэх нөхцөл байдалтайгаар үйлдсэн 3-10 жил байнсныг өөрчилж 15 жил хүртэл хугацаагаар хорих ял оногдуулахаар заасан.

2002 оны Эрүүгийн хуулиар энэ гэмт хэргийг төрийн эсрэг бусад гэмт хэргийн бүлгээс хасч захиргааны журмын эсрэг гэмт хэргийн 237-р зүйлд: Биеэрхтэндээ гэмтэл учруулах, оргон зailах, худал өвчлөх, хуурамч баримт бичиг үйлдэх, залилан мэхлэх зэргээр цэргийн жинхэнэ албаны ээлжит татлагаас зайлсхийсэн бол нэг зуугаасхоёр зуун цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэхээр зааж, зэвсэгт хүчиний бие бүрэлдэхүүнд дайчилгаагаар татагдахаас зайлсхийсэн бол нэг зуугаас хоёр зуун цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл 3 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэх, энэ гэмт хэргийг дайны буюу дайн бүхий байдал зарласан үед үйлдсэн бол хүндруулэх буюу онц хүндруулж үзэн таваас найман жил хүртэл хугацаагаар хорих ял оногдуулахаар заажээ. Түүнчлэн цаг үеийн нөхцөл байдалтай холбоотойгоор эрүүгийн хууль тогтоомжийн өөрчлөлт, шинэчлэлт бүрт энэ гэмт хэргийн талаарх зохицуулалтыг орхигдуулалгүй байсан нь бас нэгэн онцлог уламжлал байсан бөгөөд улс орны тусгаар тогтнол, батлан хамгаалах хүчин чадалтай холбоотой юм.

2. Цэрэг татлагаас зайлсхийх гэмт хэргийн бүрэлдэхүүний шинж

Энэ

гэмт

хэргийн

бүрэлдэхүүний объект нь: Батлан хамгаалах ашиг сонирхол, хэвийн үйл ажиллагаа, цэрэг татлага явуулах журам байна.³

Объектив тал нь: бие эрхтэндээ гэмтэл учруулах, оргон зailах, худал өвчлөх, хуурамч баримт бичиг үйлдэх, залилан мэхлэх арга хэрэглэж цэргийн жинхэнэ албаны ээлжит татлагаас зайлсхийсэн эс үйлдэхүй байна. Гэмт эс үйлдэхүй нь хүний биеийн идэвхтэй үйл ажиллагаа, үйлдэл хөдөлгөөнийг шаардлагтүй, харин ЭХТА-ийн хэм хэмжээнд заасан үүргийг биелүүлээгүй эсвэл түүнийг биелүүлэхээс татгалзсан, зайлсхийсэн идэвхгүй байдлаар илрэн. Гэм буруутай этгээд нь ЭХТА-ийн хэм хэмжээнд заасан үүргийг биелүүлээгүй гэдэг нь тухайн этгээд уг үүргийг огт биелүүлээгүй, биелүүлэх талаар идэвхтэй үйл ажиллагаа явуулаагүй байхыг хэлнэ.

Зохих ёсоор биелүүлээгүй гэдэгтэнэхүү үүргийг биелүүлээгүй боловч зохих ёсоор бүрэн гүйцэд биелүүлээгүй, дутуу хийсэн, ор нэр төдий хандсан, зохих журмын дагуу биелүүлээгүйг ойлгоно.

ЭХТА-д заасан үүргийг биелүүлэхээс татгалзсан гэдэг нь тухайн үүргийг биелүүлж чадахгүй гэдгээ уг хэл, үйл ажиллагаагаараа харуулж илэрхийлэх явдал юм. Харин зайлсхийх нь дээрхи үүргийг биелүүлэхээс санаатайгаар зайлсхийж, оргон зailах, арга саам эрэх, хугацаа хэтрүүлэх, хугацаанд нь биелүүлээгүй байх зэрэг үйлдлээр илрэн.

Энэ гэмт хэрэг нь хэлбэрийн бүрэлдэхүүнтэй хэрэг бөгөөд цэргийн жинхэнэ албанд татах тухай зарлан дуудах хуудас авсаны дараа заасан хугацаанд цэрэг татлагын байранд ирээгүй үеэс гэмт хэрэг төгсөнө. Цэрэг татлагын байранд ирсэн байх, өдөр цагийг аймаг нийслэлийн Засаг даргын захирамжаар тогтооно.

Цэргийн жинхэнэ алба гэж

³ С.Жанцан. Монгол Улсын эрүүгийн эрх зүй. Ерөнхий тусгай анги. УБ. 2011

Монгол Улсын иргэн Зэвсэгт хүчиний бүрэлдэхүүнд цэргийн үүргийг гүйцэтгэхийг хэлнэ. Цэргийн жинхэнэ алба нь байлдагч, түрүүчийн алба, ахлагчийн болон офицерын албанаас бүрдэх бөгөөд 18-25 насны Монгол Улсын иргэн эрэгтэйчүүдийг цэргийн жинхэнэ албанд татна.

Цэргийн жинхэнэ албаны ээлжит татлагаас зайлхийсэн гэжцэргийн жинхэнэ албанд татах тухай зарлан дуудах хуудас авсан этгээд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр цэрэг татлагын байранд заасан хугацаанд очиж бүртгүүлээгүй байхыг хэлнэ.

Хүндэтгэн үзэх шалтгаан гэдгийгцэргийн насны иргэн хүндээр өвчилсөн, хорио цээр тогтоогдсон, тээврийн хэрэгсэл саатах, гэнэтийн аюул осол, бэрхшээл тохиолдсноос цэрэг татлагын байранд тогтоосон хугацаанд ирж чадаагүй нь төрийн захиргааны төв, орон нутгийн байгууллагын тодорхойлолт, эмнэлгийн магадлагаа зэрэг албан ёсны баримтаар нотлогдсон тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй. Иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчын эрх зүйн байдлын тухай хуульд⁴ заасан доорх үндэслэл байвал хүндэтгэн үзэх шалтгаантай гэж үзнэ. Үүнд:

- Эцэг, эх нь хоёулаа, эсхүл ганц бие эцэг буюу эх нь хөдөлмөрийн чадваргүй /60-аас дээш настай эцэг, 55-аас дээш настай эх, энэ насанд хүрээгүй боловч тахир дутуугийн I, II зэрэгт орсон эцэг, эхийг хөдөлмөрийн чадваргүйд тооцно/ бөгөөд тэднийг хууль ёсоор асран хамгаалах, харгалзан дэмжих өөр хүнгүй бол хамт амьдардаг эсэхийг харгалзахгүйгээр,
- хоёр буюу түүнээс дээш хүүхэдтэй,
- эхнэр нь жирэмсэн бөгөөд сургуулийн өмнөх насны нэг

⁴ Иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчын эрх зүйн байдлын тухай хуулийн 12-р зүйл



нь цэргийн жинхэнэ албандаа татагдахаар зарлан дуудах хуудас авсан 18 насанд хүрсэн этгээд байна.

- Цэрэгтаталагаас хөлгараа, цавчих, буудах, зүү залгих, хор уух, хэлгүй дүлий болж баашлах, оршин суугаа газраа өөрчлөх, цэрэг татлагын байранд очихгүй байх, эцэг эх, ах дүүсээ нас барсан, насаа буруу тодорхойлох, хуурамч бичиг баримт бүрдүүлэх, төрсний гэрчилгээ, иргэний үнэмлэх зэрэг хувийн бичиг баримтаяа хуурамчаар үйлдэх, өөрчлөх зэрэг хэлбэрээр зайлсхийсэн байна.

- Эрүүгийн хуулийн тусгай ангийн 237.2 дугаар зүйлд заасан гэмт хэрэг нь зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүнд дайчилгаагаар татагдахаас зайлсхийдэг бол тусгай ангийн 238 дугаар зүйлд заасан гэмт хэрэг нь хөдөлмөрийн дайчилгаа болон албан журмын бусад үүрэг биелүүлэхээс, 239 дүгээр зүйлд заасан гэмт хэрэг нь байгалийн гэнэтийн аюул, хүн малын гоц халдварт өвчин, гал түймрээс эсргүүцэх улсын аюулгүй байдал хангахтай холбогдсон дайчилгаанаас зайлсхийх зэргээрээ ялгаатай

байна. Өөрөөр хэлбэл гэмт хэргийн бүрэлдэхүүний объектив талын нэмэгдэл шинж болох гэмт хэрэг үйлдсэн цаг, нөхцөл байдлуудыг үндсэн шинж болгон заасан байна.

- Цэрэг татлагын байранд тогтоосон хугацаанд хүрэлцэн ирэх үүргээ тухайн цаг нөхцөлд биелүүлэх боломжтой байх, өөрөөр хэлбэл эрхэлж буй албан тушаал, эзэмшсэн ажил мэргэжлийн байдал, ажлын болон амьдралын дадлага туршлага, ур чадвар, нас, хүйс, биеийн хүчин чадал, эрүүл мэнд, техникийн байдал, цаг агаарын зэрэг объектив нөхцөл байдлын хувьд хүрэлцэн ирэх бодит боломж, бололцоотой байх ёстой. Хэрэв дээрхи боломж, нөхцөл байдал байхгүй, хүндэтгэх шалтгаантайгаар хүрэлцэн ирээгүй бол эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй.

- Цэрэг татлагаас зайлсхийсэн этгээдэд түүний хүсэлтээр гэмтэл учруулсан этгээдийг дээрх гэмт хэргийн хамтран оролцогч гэж үзэх ба гэмтлийн зэргээс нь харгалzan Эрүүгийн хуулийн 96, 98, 99 дүгээр зүйлд заасан гэмт хэргээр давхар зүйлчилийн.

- Цэргийн жинхэнэ албанаас санаатай зайлсхийж, гадаад улс руу гарсан хууль бусаар Монгол Улсын хилийг нэвтэрсэн бол нийлмэл гэмт хэрэг гэж үзэн Эрүүгийн хуулийн 89 дүгээр зүйлд заасан гэмт хэргээр давхар зүйлчилийн.

- Цэргийн жинхэнэ албанаас зайлсхийх зорилгоор бус санамсаргүй, болгоомжгүй үйлдлээсээ болж өөртөө гэмтэл учруулан тогтоосон хугацаанд цэрэг татлагын байранд ирээгүй бол эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй.

Сүүлийн жилүүдэд цэрэг татлагаас зайлсхийх гэмт хэрэг, зөрчлийн тоо өсөх хандлагтай байгаа нь цэргийн алба хаах иргэдийн ухамсар, ёс суртахуун болон бусад хүчин зүйлээс шалтгаалах боллоо. Иймд энэ гэмт хэргийн ойлголт, бүрэлдэхүүн, тайлбар зүйлчлэлийн асуудлыг практик байгууллагын албан хаагчид зайлшгүй судлах нь гэмт этгээд ял завших, Эрүүгийн хуулийг төсөөтэй хэрэглэх, буруу зүйлчлэхээс урьдчилан сэргийлэх онол, практикийн ач холбогдолтой.

ХҮЧИНДЭХ ГЭМТ ХЭРГИЙГ ТӨСӨӨТЭЙ ЗАРИМ ГЭМТ ХЭРГЭЭС ЯЛГАН ЗҮЙЛЧЛЭХЭД АНХААРАХ АСУУДАЛ



С.Гантулга
ХСИС-ийн Цагдаагийн сургуулийн Эрүүгийн эрх зүйн тэнхимийн ахлах багши, цагдаагийн ахмад, докторант

дүгнэлт өгч байгаа ажиллагаа¹ бөгөөд зорилго нь тухайн этгээд ямар гэмт хэрэг үйлдсэн, тэр нь Эрүүгийн хуулийн ямар зүйл, заалтыг зөрчсөн болохыг ягштал тогтооход оршино.²

Хүчиндэх гэмт хэргийг Эрүүгийн хуульд заасан төсөөтэй зарим гэмт хэргүүдээс ялган зүйлчлэх нь энэ төрлийн гэмт хэрэг

үйлдэгчдэд үйлдсэн гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, хувийн байдалд тохирсон эрүүгийн хариуцлага хүлээлгэх, эрүүгийн хариуцлагын зорилгыг хангахад ач холбогдолтой.

2011-2013 онд 970 хүчиндэх гэмт хэрэг бүртгэгдэж, гэмт хэргийн улмаас 984 иргэн хохирч, 4 иргэн нас барж, 529 иргэн гэмтэж, 119.1 сая төгрөгийн хохирол учирсаны 36.9 хувийг нөхөн төлүүлжээ. 2003 оноос хойши хугацаанд бүртгэгдсэн хүчиндэх

Гэмт хэргийн зүйлчлэл бол амьдралд гарсан хэрэг үйл явдалд эрүүгийн эрх зүйн үүднээс үнэлэлт

¹С.Нарангэрэл. Гэмт хэргийг зүйлчлэх шинжлэх ухааны үндэс. УБ., 1998. 10 дахь тал

²Г.Совд. Монгол Улсын Эрүүгийн хуулийн тайлбар. УБ., 2003. 35 дахь тал



ойлгоно. Биеэ хамгаалж чадахгүй байдалтай байсан гэдэгт ухаан алдсан эмэгтэй, хөгжлийн ноцтой бэрхшээлтэй /тахир дутуу/ буюу бие организм нь эрс суларсан ноцтой өвчтэй этгээд түүнчлэн бага настай, сэтгэцийн өвчтэй хүнийг тооцно¹⁰гэж тус тус тайлбарласан байна.

Бидний үзэж байгаагаар хохирогчийн биеэ хамгаалж чадахгүй байдлыг далимдуулж хурьцал үйлдэх гэдэгт хохирогч согтууруулах ундаа, мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодис хэрэглэсний улмаас гэмт этгээдээс биеэ хамгаалах, түүний үйлдлийг эсэргүүцэх чадваргүй, хохирогч бага настай учраас хурьцлын учир холбогдлыг ойлгож, үнэлэх боломжгүй байхад нь хурьцал үйлдсэнийг ойлгох нь зүйтэй.

Хохирогч сэтгэл мэдрэлийн өвчтэй тохиолдолд сэтгэл мэдрэл сарнисан шинж чанар, хэр хэмжээ болон бэлгийн харьцааны учир холбогдлыг тухайн эмэгтэй ойлгох чадварыг сэтгэц гэм судлалын шинжээчийн дүгнэлтээр тогтоолгох шаардлагатай. Үүнийг тогтоох нь хохирогчийн биеэ хамгаалж чадахгүй байдлыг далимдуулж хурьцал үйлдсэн эсэхийг тодорхойлоход ач холбогдолтой.

Хохирогч эмэгтэйтэй ханилан суухаар амлах, эд зүйл өгөх зэргээр өөртөө татах, залилан мэхлэх, итгэл хүлээлгэсэн байдлыг ашиглан хохирогчийн зөвшөөрлөөр хурьцал үйлдсэн энэ хүчиндэх гэмт хэрэг болохгүй.¹¹

Энэ бүхнээс үзэхэд хүчиндэх гэмт хэргийн бүрэлдэхүүний объектив тал нь хохирогчид хүч хэрэглэх, хүч хэрэглэхээр заналхийлэх, бусдын биеэ хамгаалж чадахгүй байдлыг

далимдуулан хурьцал үйлдсэн идэвхтэй үйлдэл байдаг бол арван зургаан насанд хүрээгүй хүнтэй хурьцал үйлдэх гэмт хэргийн тухайд 18 насанд хүрсэн этгээд хохирогчийг 16 насанд хүрээгүй гэдгийг мэдсээр байж хурьцал үйлдсэн идэвхтэй үйлдэл байдаг бөгөөд хохирогчтой тохиролцсон байдгаараа онцлогтой. Энэ нь гэмт этгээд хохирогчид хүч хэрэглээгүй, хүч хэрэглэхээр заналхийлээгүй, биеэ хамгаалж чадахгүй байдлыг далимдуулаагүй бөгөөд хохирогчтой харилцан тохиролцсон, өөрөөр хэлбэл хохирогч гэмт этгээдтэй хурьцал үйлдэхийг зөвшөөрсөн байдгаараа ялгагдана.

B. Субъектээрээ ялгаатай.

Хүчиндэх гэмт хэргийн субъект нь 14 насанд хүрсэн, хэрэг хариуцах чадвартай этгээд байдаг бол арван зургаан насанд хүрээгүй хүнтэй хурьцал үйлдэх гэмт хэргийн субъект нь 18 насанд хүрсэн, хэрэг хариуцах чадвартай этгээд байна.

Хүчиндэх гэмт хэргийг / Эрүүгийн хуулийн 126-р зүйл/, Бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах гэмт хэргээс /Эрүүгийн хуулийн 125-р зүйл/ ялган зүйлчлэх нь:

Хүчиндэх болон бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах гэмт хэргүүд нь Эрүүгийн хуулийн 17-р бүлэг Хүүхэд, гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэг гэсэн бүлэгт хуульчлагдсан.

Практикт хуулийн байгууллагын ажилтнуудад хүчиндэх гэмт хэргийг бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах гэмт хэргээс ялан зүйлчлэхэд ихээхэн эргэлзээ төрдөг байна. Эдгээр гэмт хэргүүдийн ялгааг дараах байдлаар тайлбарлаж болно.

A. Шууд объектоороо ялгаатай

Хүчиндэх гэмт хэргийн шууд объект нь хүний бэлгийн эрх

чөлөө, халдашгүй байдал байдал бол бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах гэмт хэргийн шууд объект нь бусдын эрх, эрх чөлөө, бэлгийн халдашгүй байдал¹² байдал.

B. Объектив талын шинжээрээ ялгаатай

Хүчиндэх гэмт хэргийн объектив тал нь хохирогчид хүч хэрэглэж буюу хүч хэрэглэхээр заналхийлж, эсхүл бусдын биеэ хамгаалж чадахгүй байдлыг далимдуулан хурьцал үйлдсэн идэвхтэй үйлдэл байдаг бол бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах гэмт хэргийн объектив тал нь бусдын хүсэл зоригийнх нь эсрэг хүч хэрэглэж буюу хүч хэрэглэхээр заналхийлж, бусдын биеэ хамгаалж чадахгүй байдлыг далимдуулах, хохирогчийг тохуурхан доромжилж бэлгийн дур хүслээ ёс бусаар хангасан идэвхтэй үйлдэл байдаг. Бэлгийн дур хүслээ ёс бусаар хангахнь субъект хохирогчийг хүчиндэх, түүнтэй эр, эмийн ёсоор хурьцах зорилгогүйгээр өөрийн шалиг завхай дур сонирхолдоо хөтлөгдөн бэлгийн уламжлалт харьцааны замаар бус, садар самуун байдлаар, хохирогчийн бие, эрхтнийг тохуурхан доромжлох хэлбэрээр дур хүслээ хангах байдлаар илэрнэ¹³.

Насанд хүрээгүй болон бага наасны хүүхдийн биеэ хамгаалж чадахгүй буюу уг үйлдлийн учир холбогдлыг ойлгохгүйг далимduулан бэлгийн дур хүслээ ёс бусаар хангахдаа /хохирогчийн цавь, гуяны завсар болон аманд хийж/ заавал хүч хэрэглэсэн, биеэ хамгаалж чадахгүй байдлыг далимduулсан, тохуурхан даажигнасан бол энэ гэмт хэрэг болно.¹⁴

¹²С.Жанцан. Монгол Улсын Эрүүгийн эрх зүй /схемчилсэн тайлбар, зүйлчлэлийн асуудал/. УБ, 2011. 329 дахь тал

¹³1989 оны Улсын Дээд Шүүхийн Бүгд Хурлын 28-р тогтоо

¹⁴С.Жанцан. Монгол Улсын Эрүүгийн эрх зүй /схемчилсэн тайлбар, зүйлчлэлийн

¹⁰С.Нарангэрэл. Эрх зүйн эх толь бичиг. УБ., 2008. 542 дахь тал

¹¹С.Жанцан. Монгол Улсын Эрүүгийн эрх зүй тусгай анги. УБ., 2011. 330 дахь тал



ГЭМТ ХЭРГИЙН ЗАМААР ОЛСОН БОХИР МӨНГИЙГ УГААХ ҮЙЛДЛИЙГ /ЭС ҮЙЛДЭХҮЙ/ ЭРҮҮЖҮҮЛЭХ ҮНДЭСЛЭЛ, ҮЙЛ ЯВЦ

Ж.Төгс-Очир
Хууль сахиулахын их сургуулийн докторант

Хүн, иргэдийнхээ эрх, эрх чөлөөг элдэв гэмт халдлагаас хамгаалах нь аливаа ардчилсан төрийн хамгийн чухал чиг үүрэг юм. Энэ үзэл санаа төрөөс гэмт хэрэгтэй тэмцэх эрүүгийн бодлогын үндэс болдог бөгөөд төр гэмт явдлыг, тухайлбал, түүний хамгийн аюултай төрлийг гаргуулахгүй байх, гаралтыг нь аажмаарцөөрүүлэх, таагүй үр дагаврыг арилгах, хууль сахиулах байгууллагуудын үйл ажиллагааг хууль тогтоомжийг боловсронгуй болгоход чиглэгдсэн нийгэм-эдийн засаг, эрх зүй, зохион байгуулалтын болон техникийн шинжктэй цогц арга хэмжээ авч хэрэгжүүлэх шаардлагатай.

Монгол Улсын Үндсэн хуулийн 16-р зүйлийн 3 дахь хэсэгт “Хөдлөх, үл хөдлөх, эд хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх, өв залгамжлуулах эрхтэй. Хувийн өмчийг хууль бусаар хураах, дайчлан авахыг хориглоно”, 19-р зүйлийн 10 дахь хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахайц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна”¹ гэж заасан. Төр иргэнийхээ эдийн засгийн эрх чөлөө, өмчлөх эрхийг гэмт халдлагаас найдвартай хамгаалахын тулд эрх зүйн олон салбарын хэм хэмжээг хэрэглэдэг бөгөөд тэдгээрийн дотроос Эрүүгийн хуулиар нийгэмд аюултай тодорхой үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэгт тооцож, эрүүгийн хариуцлага хүлээлгэх арга өргөн хэрэглэгддэг.

Мөнгө угаах үйлдэл нь улс орны

эдийн засгийн аюулгүй байдалд бодитой аюул учруулдаг болохыг дэлхий нийтээр хүлээн зөвшөөрч, шийдвэртэй тэмцэл өрүүлж байна. Тухайлбал, FARF (Financial Action Task Force)-ын мэдээгээр дэлхийн бүх улс орнуудад жил бүр 500 тэрбумаас 1,5 их наяд хүртэл хэмжээний доллар угаагдаж байна.

Эдгээр их хэмжээний мөнгө хүнд, онц хүнд гэмт хэргийн бодит үр дүн бөгөөд мөнгө угаагчид, авилагч түшмэдүүд тэдгээрийг оффшор бүсүүдүү шилжүүлж, дараа нь гадаадын хөрөнгө оруулалт нэрийн дор өөрийн орондоо эргүүлж авчирдаг болохоор улс орны эдийн засагт бодитой аюул учруулах боломжтой юм.²

Монгол Улсын Их хурлын 2010 оны 7-р сарын 15-ны өдрийн 48-р тогтоолоор батлагдсан “Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-д эдийн засгийн бие даасан байдлаа хангаж хөгжих, байгальд ээлтэй, иргэний аюулгүй, амгалан амьдрах боломжийг бүрдүүлсэн тогтвортой хөгжлийн загварыг бий болгох нь эдийн засгийн аюулгүй байдлыг хангах үндэсн нөхцөл мөн, эдийн засгийн олон тулгуурт, оновчтой бүтцийг бий болгох, хөрөнгө оруулалтын тэнцвэртэй бодлого явуулах, санхүүгийн салбарын аюулгүй байдлыг баталгаажуулах, эрчим хүч, эрдэм баялагийн аюулгүй болон гадаад худалдаа, интеграцийн асуудлаар оновчтой бодлого баримтлана. Эдийн засгийн аюулгүй байдлыг хангах, урт хугацааны өсөлт хөгжлийг дэмжих эрүүл, тогтвортой, сахилга баттай санхүүгийн салбарыг

төлөвшүүлнэ”.

“Монгол хүний эрүүл аюулгүй амьдрах таатай орчин, нөхцөлийг бүрдүүлэх, хүнсний аюулгүй байдлыг хангах, амьдрах орчин, орон байрны аюулгүй нөхцөлийг баталгаажуулах, гэмт хэрэг, халдлагын золиос болохоос хамгаалах нь хүний аюулгүй байдлыг хангах үндэс мөн”³ гэж тус тус баталгаажуулсан нь гэмт хэрэгтэй тэмцэхэд төрөөс баримтлах бодлогын үндэс мөн. Эрүүгийн хууль бол төрийн эрүүгийн бодлогыг хэрэгжүүлэх хүчтэй хэрэгсэл юм.

Нийгэм, төр, байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн хуулиар хамгаалагдсан эрх ашиг, сонирхолд хор хохирол учруулах болсон, нийгмийн хор аюул ихтэй, эрх зүйн бусад салбарын хэм хэмжээгээр хариуцлага тооцох боломжгүй тийм үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэгт тооцож эрүүжүүлэх зайлшгүй шаардлага амьдралаас урган гардаг. Нийгэмд үлэмж аюултай үйлдэл, эс үйлдэхүйг эрүүжүүлэх үндэслэл буюу криминологийн, нийгэм-эдийн засгийн, нийгэм-сэтгэл зүйн хэд хэдэн хүчин зүйлүүд үйлчилдэг.

Эдгээр объектив хүчин зүйлүүдэд а) тухайн үйлдэл, эс үйлдэхүйн нийгмийн хор аюулын хир хэмжээ; б) их хэмжээгээр үйлдэгдэх болсон; в) тэдгээртэй эрүүгийн хуулийн хэм хэмжээгээр тэмцэхээс өөр арга замгүй болсон зэрэг хамаарна.

Эдийн засгийн болон мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх гэмт үйл ажиллагаатай хийх тэмцлийн чиглэлийг төрийн гэмт хэрэгтэй тэмцэх (эрүүгийн бодлого) бодлогоор тодорхойлдог.

¹ Монгол Улсын Үндсэн хууль 2012 он, 13, 15 дахь тал

² Л.Н.Анисимов. Международные правовые средства противодействия легализации незаконных доходов. М. 2009. 83-84 дэх тал

³ Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал. УБ., 2010. 6 дахь тал



бусдын эд хөрөнгийг завших, үрэгдүүлэх замаар их буюу онц их хэмжээний хохирол учруулсан нь ялыг онц хүндруүлж (5-10 жил) оногдуулахаар хуульчилсан нь халдлагын зүйлийн хэмжээтэй холбоотой байна. Эдгээр халдлагын зүйл болох мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодисыг хууль бусаар бэлтгэсэн, олж авсан, хадгалсан болохоор л нийгэмд аюултай болж байгаа юм.

Мөнгө угаах гэмт хэргийн гаралт сүүлийн үед ихсэх хандлагатай болж байгаа нь түүний нийгэмд аюултай шинжийг илэрхийлэх нэг үзүүлэлт мөн. Тухайлбал, МИАТ-ийн захирлууд болон Эрүүл мэндийн яамны түшмэдүүд, Татварын ерөнхий газрын албан тушаалтуудын хэрэг мөнгө угаахтай шууд холбогдон шалгагдах боллоо.

Манай хойд хөрш ОХУ-д мөнгө угаах явдал бодит байдал болсон учраас Эрүүгийн хуульд мөнгө угаахыг 1996 оноос эрүүжүүлсэн. ОХУ-ын Санхүүгийн хяналтын хорооны мэдээгээр 2011 оны байдлаар тус улсын мөнгөний нийт эргэлтийн 40-70 хувийг бохир мөнгө эзэлж, улс орны эдийн засгийг сүйрүүлэх хэмжээнд хүргэж байна.⁵

Манай улсын хувьд мөнгө угаах гэмт хэрэг ихсэх хандлагатай болсон бөгөөд одоогоор мөрден байцаалт, шүүхийн шатанд шийдвэрлэгдсэн цөөн тооны хэргээр энэ гэмт хэргийн гаралтыг дүгнэж хэрхэвч болохгүй. Учир нь энэ гэмт хэрэг **нэгд**, зохион байгуулалттай халхавчилсан арга хэрэгслээр үйлдэгдэг; **хоёрт**, энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх эрх зүйн орчин боловсронгуй биш; **гуравт**, мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх, илрүүлэн шалгах нотлох үйл ажиллагааны туршлага дутмаг зэрэг бодит нөхцөл байдал

энэ гэмт хэрэгтэй тэмцэхэд саад учруулж байгаа юм. Гэхдээ энэ төрлийн бэрхшээл нь мөнгө угаах үйлдлийг эрүүжүүлэхэд саад болох учиргүй.

Гэвч мөнгө угаах үйлдлийг (эс үйлдэхүй) гэмт хэрэгт тооцож хуульчлах нь энэ гэмт хэрэгтэй эрүүгийн хариуцлагын арга хэмжээгээр үр дунтэй тэмцэх, мөнгө угаагчдад гэмт үйлдлээс татгалзах, ингэснээр урьдчилан сэргийлэх нөлөөлөл үзүүлж байгаагаар аль ч талын ач холбогдолтой. Тэгээд ч энэ төрлийн гэмт хэрэгтэй эрүүгийн хариуцлагын арга хэмжээнээс гадна иргэний болон захиргааны хариуцлагын арга хэмжээгээр үр нөлөөтэй тэмцэх боломжгүй гэдгийг олон улсын практик харуулж байна.

Мөнгө угаах гэмт хэргийг эрүүжүүлэх нийгэм-эдийн засгийн үндэслэлд:

а) энэ гэмт хэргийн улмаас учирсан материаллаг болон ёс суртахууны хохирол;

б) эрүүгийн хариуцлага хүлээлгэх болсноос үүсч болох дагалдах хор уршиг;

в) эрүүгийн хариуцлагыг бодитойгоор хэрэгжүүлэх материаллаг нөөц боломж зэрэг хүчин зүйлүүд хамаарна.

Энэ төрлийн гэмт хэргийн улмаас нийгэмд янз бүрийн хохирол учирч болно. Мөнгө угаагчид **нэгд**, хүнд болон онц хүнд гэмт хэрэг үйлдэж олсон мөнгө, хөрөнгийн гэмт эх үүсвэрийг янз бүрийн аргаар далдалж, цаашдын гэмт үйл ажиллагааг санхүүжүүлэх замаар хууль бус орлого олдог учраас хууль ёсны мэт ойлгогдож тэдгээрийг мөрдөн шалгах, нотлох талаар хийгдэх хууль сахиулах байгууллагын үйл ажиллагааг улам хүндруүлдгээрээ хор аюул ихтэй байdag.

Мөнгө угаагчдын гэмт үйлдлийг тэр бүр түргэн шуурхай, бүрэн гүнзгий илрүүлэх, нотлох боломж хомс

байдгаас тэд илчлэгдэхгүйгээр гэмт үйл ажиллагаагаа чөлөөтэй үргэлжлүүлж нийгэм, иргэдэд ноцтой хохирол учруулах боломжтой болдог нь мөнгө угаах үйлдлийг гэмт хэрэгт тооцох нэг үндэслэл юм.

Мөнгө угаах гэмт хэрэгт зайлшгүй эрүүгийн хариуцлагын хэм хэмжээ хэрэглэх шаардлагань **нэгд**, угаах мөнгөтэй болох зорилгоор асар богино хугацаанд их хэмжээний орлого олох боломжтой эдийн засгийн болон хар тамхины хууль бус эргэлтэй холбоотой суурь гэмт хэргүүд болон тэдгээрийг үйлдэж олсон бохир мөнгийг угаах нь өөрөө нийгэмд аюултай үйлдэл юм. **Хоёрт**, суурь гэмт хэргүүдийг гол төлөв хувийн байдлаараа нийгэмд харш зан төлөвтэй, нарийн зохион байгуулалтад орсон, архаг гэмт хэрэгтнүүд үйлддэг зэрэг объектив болон субъектив нөхцөл байдлаас урган гарч байна.

Хууль сахиулах болон шүүх эрх мэдлийн байгууллагын ажилтнууд мөнгө угаах үйлдлийн онцлог шинж, үйлдлийн арга зам, мөнгө угаагчдын криминологи шинжийг тодорхойлох, мөнгө угаах гэмт хэрэгт эрүүгийн хариуцлага хүлээлгэх хэм хэмжээг зөв тайлбарлах, хэрэглэх, мэдлэг, ур чадвартай болж бэлтгэгдсэн байх нь энэ төрлийн гэмт үйлдлийг эрүүжүүлэх урьдчилсан нөхцөл юм.

Гэмт хэргийн аргаар олсон мөнгө угаах үйлдэлд эрүүгийн хариуцлага хүлээлгэж буй Эрүүгийн хуулийн хэм хэмжээнд бодитой, оновчтой үнэлэлт өгөхийн тулд тэдгээрийг үндэсний болон олон улсын шинжтэй тодорхой нөхцөл байдлын үйлчлэл, нөлөөгөөр тодорхой хууль тогтоох үйл ажиллагааны үр дүн гэж үнэлж дүгнэх ёстой.

БНХАУ, ОХУ-ын санхүүгийн луйвар хийдэг гэмт бүлэглэлүүд элдэв халхавчийн дор хар тамхи, мансууруулах бодис, зэвсэг, хүн

⁵ В.А.Зубков. Формирование и развитие системы финансового мониторинга в Российской Федерации М., 2008. 20-21 дэх тал



хулгайлалгасан болон бусад бараа бүтээгдэхүүний хууль бус наймаа (155.1 дэх хэсэг) зэрэг нь багтана. Эдгээр гэмт хэрэг нь хөнгөн гэмт хэргийн төрөлд багтах бөгөөд хөнгөн шийтгэлтэй тул 166¹.1 дэх заалтын хүндэвтэрээс дээш гэмт хэргийн төрөлд багталгүй сугарч үлдсэн байна.

Нөгөө талаас, Эрүүгийн хуульд зохиогчийн эрхийг зөрчих (piracy), компанийн мэдээллийг хууль бусаар наймаалах (insider trading), зах зээлийн үнийг хууль бусаар хөөрөгдөх (market manipulation) үйлдлүүдийг гэмт хэрэгт тооцоогүй байна.

Эрүүгийн хуулийн 166¹.1 дэх хэсэгт заасан эд хөрөнгө, эдийн бус хөрөнгө болон мөнгө, эдгээрийн Иргэний хуулийн 84 дүгээр зүйл дэх холбогдох заалт нь Вена болон Палермогийн конвенц дахь эд хөрөнгөтэй холбоотой олон улсын стандартуудыг хангаж байгаа бололтой. Гэвч Эрүүгийн хууль дахь “гэмт хэрэг үйлдэж олсон орлого”-ын тодорхойлолт (166.1 дэх хэсэг болон ерөнхий анги дахь) нь олон улсын хэрэгслүүдэд тусгагдсан үзэл баримтлалаас

харьцангуй бага хүрээг хамарч байгаа бөгөөд олон улсын стандартад нийцэхгүй байна.

Үүнээс гадна мөнгө угаах үндсэн гэмт хэрэгт Монгол Улсаас гадна үйлдэгдсэн гэмт хэргийг хамруулаагүй, мөн зөвхөн Монгол Улсын олон улсын гэрээнд заасан тохиолдолд гадаадын иргэнд хуулиар хариуцлага хүлээлгэнэ (Эрүүгийн хуулийн 14 дүгээр зүйл) гэж хязгаарлажээ.

Мөнгө угаах гэмт хэрэгт эрүүгийн хариуцлага хүлээлгэж буй хэм хэмжээг олон улсын эрх зүйд нийцүүлэх, хийдлийг арилгах шаардлагатай байгааг харгалzan Эрүүгийн хуулийн 166¹-р зүйлийн 166¹.2 дахь хэсгийн хууль бус эх үүсвэрийг нь халхавчлах, нуун далдлах, түүнчлэн аливаа этгээдийг хуулийн хариуцлагаас зайлсхийхэд туслах зорилгоор эд хөрөнгийг гэмт хэрэг үйлдэж олсон орлого гэдгийг нь мэдсээр байж өөрчилсөн эсвэл шилжүүлсэн бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоер зуун тавиас таван зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох эсвэл найман жил хүртэл хугацаагаар

хорих ял шийтгэнэ” гэж,

“Энэ хуулийн 166¹.1 дэх хэсэгт заасан гэмт хэргийг хуулийн этгээд үйлдсэн бол түүнийг тавиас таван зуун сая хүртэл төгрөгөөр торгох, эсвэл татан буулгах (дампууруулах) ял шийтгэнэ” гэж;

“166¹.1. Эд хөрөнгийг гэмт хэрэг үйлдэж олсон орлого гэдгийг нь мэдсээр байж түүний бодит шинж чанар, эх үүсвэр, байршил, захирэн зарцуулах арга, эзэмшигч буюу эд хөрөнгийн эрхийг нуусан, далдалсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох эсвэл таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ” гэж;

“166¹.1. Гэмт хэрэг үйлдэж олсон орлого гэдгийг мэдсээр байж эд хөрөнгийг олж авсан, эзэмшсэн юмуу ашигласан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэг дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох эсвэл нэг жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ” гэж тус тус өөрчлөн найруулах шаардлагатай гэж үзэж байна.

ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ЭРҮҮГИЙН ХАРИУЦЛАГА ХҮЛЭЭЛГЭХ ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГА



Нэг. Оршил

Зах зээлийн нийгмийн харилцаа бүрэн нэвтэрч, төлөвшөөгүй тогтвортой хөгжлийн орчин бий

болж чадаагүй оронд гэмт хэргийн шинэ төрлүүд далд хэлбэрээр оршиж, гэмт хэрэг үйлдэгч субъектын хүрээ өргөжин, гэмт зан үлийн сөрөг нөлөөллийг тогтоон барих эрүүгийн эрх зүйн үр ашигтай механизм бүрэлдэж амжаагүй байдгаас үүдэн албан тушаалтууд төдийгүй хуулийн этгээд ял завших боломжийг бий болгосоор байна. Байгаль орчин /ой/, гол горхи, агаар, газрын хөрс, ургамал, ан амьтан/бохирдуулах, Аж ахуйн эсрэг гэмт хэрэг болох “мөнгө угаах”, үнийг хууль бусаар өсгөх, зах зээлд

шударгаар өрсөлдөх боломжийг хааж, дангаар ноёрхох, монополь тогтоох, хууль бусаар лиценз олгох, хуулиар зөвшөөрөөгүй нөхцөлд хууль бус аргаар барилга барих, газар эзэмших, татвараас зайлсхийх, залилан мэхлэх замаар бусдыг төөрөгдүүлж гэрээ хэлцэл хийх, хууль бус хуурамч баталгаа, баримт гаргаж өгөх зэрэг олон гэмт хэргийн эзэн холбогдогч нь зөвхөн албан тушаалтан болон хуулийн этгээд хоёрын дунд эзгүйдэж, хариуцлага хүлээх этгээд нь чухам хэн болох нь тодорхойгүй байсаар хариуцлага хүлээх хугацаа өнгөрч



байгуулагсан байхын дээр эрүүгийн хууль тогтоомжид заасан нөхцөлүүдийг бүрэн хангасан байхад оршино.

4. Нэг талаас эрүүгийн хуулиар хориглосон гэмт хэргийг тухайн хуулийн этгээд өөрийн нэрээр зориуд үйлдсэн нь ямар нэгэн албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх нөхцлийг үгүйсгэх байдал бий болсон, нөгөө талаас гэмт хэргийн үйлдэл нь тухайн байгууллагад ашигтай, давуу, илүү байдал бий болгоход шууд чиглэсэн буюу зарим тохиолдолд албан тушаалтны хүлээх ялтай давхардахгүйгээр хуулийн этгээд тусдаа эрүүгийн хариуцлага хүлээх шаардлага зайлшгүй бий болсон байх ёстой.⁷

5. Хуулийн этгээдэд хүлээлгэх эрүүгийн хариуцлага нь тухайн аж ахуйн нэгжийн удирдах болон гүйцэтгэх албан тушаалтан гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд байгууллага өөрөө эрүүгийн хариуцлагын субъект болох болно. Мөн хуулийн этгээдийг дангаар нь буюу албан тушаалтны хамт давхар хариуцлагад тооцож болохоор дэлхийн улс орнууд өөрийн хуулиндаа тусган хэрэгжүүлсээр байна. Үүнийг хамтын хариуцлагын онол гэх бөгөөд Францын эрдэмтэд (Р.Мерль, А.Витю) нар хуулийн этгээдийг хамтын хариуцлагын субъект /гэмт хэргийн субъект/ гэж үзэж болох нөхцөлийн үндсэн шалтгаан үндэслэлд доорхи зүйлийг тусгасан:

- Хуулийн этгээдийг төлөөлөх коллеги, зөвлөлийн хамтын шийдвэрээр уг үйлдлийг дэмжсэн ба санаачлан үйлдсэн байх;

- Удирдах буюу эрх бүхий албан тушаалтны гэмт үйлдлэлтэй давхардаагүй буюу тусдаа бүрэлдхүүнтэй байх зэргийг хамааруулдаг ажээ;

- Хуулийн этгээдэд ашигтай боловч бусдад хохирол, үр дагавар

учруулсан байх;

- Хуулийн этгээдийн нэрийн өмнөөс хийгдсэн байх⁸

6. Позитив онолын хандлагаар Бельги, Дани, Франц, Исланд зэрэг зарим оронд хувийн хуулийн этгээдээс гадна нийтийн эрх зүйн хуулийн этгээд болон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага гэмт хэргийн субъект болдог практик бий. Харин Ирак, Хятад, Литва, Молдав, Норвеги, Эстони зэрэг оронд зөвхөн хувийн эрх зүйн хуулийн этгээд тэр тусмаа арилжааны компаниуд эрүүгийн хариуцлага хүлээх субъект болдгоороо онцлогтой.

7. Негатив онолын үүднээс Германы эрүүгийн эрх зүйд хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх асуудал нь олон жилийн турш маргаантай байсаар ирсэн бөгөөд ихэнхи эрдэмтэн хуулийн этгээдэд ийнхүү хариуцлага хүлээлгэх нь зүй бус, үндэслэлгүй гэж үздэг байжээ. Энэхүү үзэл бодлоо “societas delinguere non potest” / хамтарсан субъект гэмт хэрэгтэн байж болохгүй/ гэсэн латин хэллэгээр тайлбарладаг.⁹ Гэхдээ Герман улс сүүлийн үед эрүүгийн хариуцлагын тогтолцоог анхааран судалж байгаа нь ажиглагдаж байна. Германы зарим эрдэмтэн тухайлбал, Ахенбах, Тидеманн, Х.Хартан нар хууль тогтоогчдыг хувь хүний хариуцлагын системийг баримталж байгааг эсэргүүцэж, энэ нь одоогийн цаг үед нийцэхгүй гэж үзэж байна. Тухайлбал, К.Хартан Германы болон Францын эрх зүй дэх хуулийн этгээдийн хариуцлагын асуудлаар харьцуулалт хийсэн байх бөгөөд Францын эрх зүйн зохицуулалтыг давуу гэдгийг онцолж, Германыг энэ замаар явах хэрэгтэй гэж үзэж эрх зүйн системийн хувьд хуулийн этгээдийн зарим ажилтанд

торгуулийн ял оноох нь бодитой үйлчилж байгаа арга биш бөгөөд хуулийн этгээдийн үйлдсэн хууль бус үйлдлийг хэн нэгэн ажилтан хариуцаж торгууль төлснөөр, тухайн хуулийн этгээд өөрийн техник хангамжийг сайжруулах үүрэг хүлээхгүй тул зарлага гаргахгүй байдлаараа ашигтай байдлаа хадгалан үлдсээр байна гэж тэдгээр эрдэмтэд үзсэн байна.”¹⁰

Хуулийн этгээдэд оногдуулах эрүүгийн хариуцлагын хувьд ямар гэмт хэрэгт, ямар ялыг, эрх зүйн ямар механизмыг ашиглан оногдуулах вэ гэдэг нь чухал асуудлууд бөгөөд дэлхийн улс орнууд эдгээр ойлголтуудын хүрээнд өөр өөрийн онол, загварыг баримтлан хэрэгжүүлж байна. Одоогийн байдлаар АНУ корпорацид харьцангуй олон төрлийн ял шийтгэлийг оногдуулж байгаагаараа, мөн ямар ч төрлийн ажилтныхаа өмнөөс хариуцлага хүлээдэг гэсэн чиг хандлагыг баримталдаараа ихээхэн үр нөлөөтэй гэж үзэж болох юм. Мөн Англи улс хуулийн этгээдэд хариуцлага хүлээлгэх тусгайлан хуультай бол АНУ, Франц, Австрали зэрэг улс эрүүгийн хуульдаа тусгайлан заасан байна. Харин Япон, Сингапур зэрэг улс бусад хууль тогтоомжоороо зохицуулсан байдаг.

Хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх онол буюу загварын хоёр төрөл байдаг:¹¹

1. Үүсмэл хариуцлага

- Төлөөлөн хүлээх хариуцлага /АНУ/ - тухайн компани ямар ч ажилтныхаа өмнөөс эрүүгийн хариуцлага хүлээдэг.

- Адилтгалын хариуцлага / Англи/ - зөвхөн удирдах түвшний этгээдийн хийсэн үйлдэлд компани хариуцлага хүлээдэг.

⁷Д.Баярсайхан. Эрх зүйн сэргэлгээний орчин цагийн асуудал.УБ., 2012. 49 дэх тал.

⁸Л.Иванов, “Германы хуульчдын хуулийн этгээдийн хариуцлагын судалгаа” Право и Экономика сэргүүл, 2008/128 , 104 дахь тал

⁹Мөн тэнд.

¹⁰Уголовный Кодекс Голландий СП.Б.Юридический Центр.Пресс 2000.



одоо хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэдэг болсон байна. Үүнээс жишээ болгон доорхи зарим оронд хуулийн этгээдэд оногдуулах эрүүгийн хариуцлагын талаар хуулиндаа зохицуулсаныг тусгав.

Герман улс

Германы эрүүгийн эрх зүйд хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх асуудал нь олон жилийн турш маргаантай байсаар ирсэн ба ихэнхи эрдэмтэд хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх нь зүй бус, үндэслэлгүй хэмээн үздэг байсан. Энэхүү үзэл бодлоо хамтарсан субъект гэмт хэрэгтэн байж болохгүй гэж тайлбарладаг.¹⁴ Гэхдээ Германы эрдэмтэд сүүлийн үед үүнийг ихээр шүүмжлэн эрүүгийн хариуцлага хүлээлгэдэг болох нь зүйтэй хэмээн үзэж байна.

Франц улс

Францын эрүүгийн хуулийн 121-2-т Хуулийн этгээдэд хүлээлгэх эрүүгийн хариуцлагыг хувь хүн, албан тушаалтанд оногдуулах ялаар орлуулан тооцож болохгүй. Мөн уг гэмт хэрэгт гүйцэтгэгч ба хамтран оролцогчдын гэмт үйлдлийг яланг зааглаж, хариуцлагыг хамтад нь хүлээлгэж болохоор зүйлчилсэн байна.¹⁵

Хуулийн этгээдэд оногдуулах эрүүгийн хариуцлагын хувьд ихэхнээ торгох, эрхийг хязгаарлахгүй үйл ажиллагааг зогсоох зэрэг ялыг хэрэглэдэг. Францын эрүүгийн хуульд заасан санкцаас үзэхэд: Хувь хүн, албан тушаалтанд хүлээлгэх торгуулиас наад зах нь тав дахин илүү төлбөр торгуулийг хуулийн этгээдэд оногдуулах;

1. Таван жилээс дээш хорих ял шийтгүүлэхээр (минимум) гэмт хэрэгт хувь хүн албан тушаалтан биш; харин тухайн байгууллага холбогдон эдлэх нөхцөлд уг хуулийн этгээдийн үйл ажиллагаа

явлжлах эрхийг зогсоох, хүчингүй болгох;

2. Таван жил хүргэл ял шийтгүүлэхээр альтернатив гэмт хэргийг хуулийн этгээд үйлдсэн нөхцөлд үйл ажиллагааг нь хязгаарлах, тодорхой хугацаанд хориглох;

3. Гэмт хэргийн замаар олсон орлого, эд зүйлс бүтээгдэхүүнийг хураах гэх мэт. Түүнчлэн чек, хувьцаа гаргах эрхийг хязгаарлах, хориг тавих зэргээр шүүхийн хяналтанд 5-аас дээшгүй жил цагдан хянах, хяналтад байлгах зэрэг ялын төрлүүдийг тогтоосон байдаг. Францад гэмт хэргийн ангилалтаас хамаарч хуулийн этгээдэд 50-250 сая хүргэл европийн торгууль ногдуулдаг ба торгууль төлж чадахгүй хуулийн этгээдийг албадан татан буулгадаг.¹⁶

Япон улс

Эрүүгийн хуулиндаа хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх талаар хуульчилж өгөөгүй хэдий ч бусад хуулиндаа хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага ноогдуулах талаар заасан байдаг. Тухайлбал Шударга бус өрсөлдөөнөөс хамгаалах тухай хууль, компанийн, татварын хууль зэрэг хуулиудад хувь хүн болон хуулийн этгээдэд аль алинд нь эрүүгийн хариуцлагын торгох ялыг ногдуулна гэж заасан байдаг. Өөрөөр хэлбэл хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлагын торгох ялыг харин хувь хүнд торгох, хорих зэрэг эрүүгийн бусад ялыг ногдуулж давхар шийтгэдэгэрээ онцлогтой юм. Мөн Японы Дээд шүүх корпораци нь өөрийн ажилтныг ажил үүргээ гүйцэтгэх явцдаа гэмт хэрэг үйлдэхээс сэргийлэх бодлого, тогтолцоог бий болгож, хэрэгжүүлж байх ёстой гэсэн шийдвэр гаргасан бөгөөд хэрвээ тийм бодлого баритлаагүй болон түүнийгээ шинчлэн сайжруулаагүйгээс болоод гэмт

хэрэг үйлдэгдсэн байвал тэр нь хуулийн этгээдийн эрүүгийн хариуцлага хүлээх үндэслэл мөн гэж үзсэн байна.¹⁷

БНХАУ

Хятад улсад хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх асуудал 1979 оноос хуулиндаа тусгах талаар яригдаж эхэлсэн асуудал нь өдгөө эрүүгийн хуулиндаа хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх ойлголт нь “нэгжийн гэмт хэрэг” гэсэн ойлголтоор илэрхийлэгдэг болсон байна. БНХАУ-ын эрүүгийн хуулинд “нэгжийн гэмт хэрэг” гэсэн ойлголтыг оруулж ирсэнээрээ ихээхэн өвөрмөц онцлогтой ба энэхүү ойлголтод зөвхөн корпораци төдийгүй бусад этгээдүүдийг хамруулан заасан байдаг байна. Тус улсын эрүүгийн хуулийн 30 дугаар зүйлд “компани, аж ахуй нэгж байгууллага зэрэг этгээдүүд нийгэмд аюултай гэмт хэрэг үйлдсэн ба тэрхүү гэмт хэргийг нь тухайн нэгжүүдийн үйлдэх гэмт хэрэг гэж тодорхойлж эрүүгийн хариуцлага ногдуулна” гэсэн байна.¹⁸ Эрүүгийн эрх зүйн зохицуулалт нь мөн л хуулийн этгээдэд, хувь хүнд давхар эрүүгийн хариуцлага хүлээлгэдэг байна.

ОХУ

ОХУ нь нэг талаас эх газрын эрх зүйн тогтолцооны зүүн чиглэлд хамаарах төрөлжсөн эрүүгийн хууль тогтоомж бүхий улс, нөгөө талаас хосолсон институци бүхий постсоциалист орны ангилалд багтажын дээр өөрийн эрх зүйн үнэт зүйл, нөлөөлөл, байр сууриа харьцангуй тогтвортой хадгалж ирсэн. Тус улс нь нэгдмэл, төрөлжсөн Эрүүгийн хуультай бөгөөд эдийн засаг, экологи, татвар, төсөв, захиргааны журам зөрчсөн болон бусад бланкет диспозитэй хэргүүдийг тусдаа хуулиар бус материаллаг эрх зүйн

¹⁴Criminal code of the Federal Republic of Germany.,1998.

¹⁵Criminal Procedure Code of the French Republic 1992.

¹⁶Д.Баярсайхан. Эрх зүйн сэтгэлгээний орчин цагийн асуудал. УБ., 2012. 51 дэх тал.

¹⁷S. Odongerel .Corporate criminal liability in today's world.

¹⁸Criminal law of the people's Republic of China. 1997.



хүлээлгэхдээ тусгай хуультай Англи, Эрүүгийн хуулиндаа тусгасан орнуудаас АНУ, Франц, Австрали, Хятад, харин бусад холбогдох хууль тогтоомжинд заасан Япон, Сингапур улсууд зэрэг орнууд байна. Иймээс гадаадын улс орнууд эрх зүйн өөр өөрийн онцлог, арга зүйгээр хандаж байгаа тухай дээр бичсэн бөгөөд хэрэгжүүлж байгаа механизм, арга барилын тухайд мөн л ялгаатай байгаа нь анзааргдаж байна. Ийнхүү гадаад улс орнуудын эрүүгийн хууль тогтооомжид хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэн хуульчилж хэрэгжүүлж байгаа өнөө үед уг асуудлыг Монгол улсын эрүүгийн эрх зүйн шинжлэх ухаанд авч үзэн судалж, нарийн судалгаа шинжилгээг шаардлагатай байна.

Дөрөв. 2007 оны Дэлхийн Эрүүгийн загвар хууль дахь хуулийн этгээдийн талаарх зохицуулалт, тайлбар

19 дүгээр зүйл. Хуулийн этгээдийн хариуцлага

1. Дараах тохиолдолд хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэн:

а. Хуулийн этгээдийн нэр дээр, нэрийн өмнөөс эсвэл түүний ашиг тусын төлөө гэмт хэрэг үйлдэгдсэн;

б. Хуулийн этгээд болох байгууллагын хэсэг бүлэг хүмүүс түүнчлэн ганцаарчилсан хувь хүнээр үйлдэгдсэн байх бөгөөд тэрхүү этгээд нь тухайн хуулийн этгээдийн хувьд менежментийн болон хяналтын байр суурьтай байх:

1. Төлөөлөх бүрэн эрхтэй этгээд;

2. Хуулийн этгээдийн нэрийн өмнөөс шийдвэр гаргах эрх бүхий этгээд;

3. Хуулийн этгээдэд хяналт тавих бүрэн эрх бүхий этгээд.

2. Хуулийн этгээдийн ашиг тусын тулд гэмт хэрэг үйлдэх боломжтой Параграф б-д заасан этгээдийн гүйцэтгэх болон хяналт тавих үүргээ хэрэгжүүлээгүйн улмаас үүссэн гэмт хэрэгт

хариуцлага хүлээлгэнэ.

3. Хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх нь тухайн гэмт хэргийг үйлдсэн хувь хүнд хүлээлгэх эрүүгийн хариуцлагыг хэрэгсэхгүй болгохгүй.

Хуулийн этгээдэд оногдуулах ялын төрөл

Шүүх хуулийн этгээдэд дараах ялыг хослуулан оногдуулж болно:

1. гэмт хэрэг үйлдэхэд тусгайлан бэлтгэсэн багаж, гэмт хэрэг үйлдэхэд хэрэглэсэн хэрэгсэл, тоног төхөөрөмж, эд хөрөнгө зэргийг хураан авах;

2. хохирогчид нөхөн төлбөр төлөх;

3. торгох;

4. хуулийн этгээдийн эд хөрөнгийг хураан авах;

5. хуулийн этгээдийг татан буулгах;

6. шүүхийн шийдвэрийг олон нийтэд мэдээлэх;

7. тодорхой үйлдвэрлэл, үйлчилгээ явуулахыг хугацаатай болон хугацаагүйгээр хориглох.

Тайлбар: Компани гэмт хэрэг үйлдэж чадахгүй гэж үздэг эртний онол сургаал одоо олон улсын болон дотоодын түвшний практикт хоцрогдсон ойлголт бөгөөд анхнаасаа эрүүгийн хууль нь тодорхой үйлдэлд ёс суртахууны хувьд гэм буруутай байх зарчимд тулгуурласан учраас хуулийн этгээд нь ёс суртахууны гэм буруугийн чадамжгүй учраас энд тохиромжгүй гэж тооцогддог байсан.

Гэвч энэ үзэл баримтлал нилээд өөрчлөгдсөн ялангуяа одоогийн гэмт хэргийн чиг хандлагатай уялдаж өөрчлөгдж байна. Орчин үед зохион байгуулалттай гэмт хэрэг, авилга, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх гэх мэт ноцтой гэмт хэргүүд хуулийн этгээд түүнчлэн хувь хүнээр үйлдэгдэж байна. Хуулийн этгээдийн цогц бүтцээс үзэхэд энэ нь гэмт хэрэг үйлдсэн хувь хүнтэй адилтгахад энэ заримдаа хэцүү байж болох юм. Гэхдээ

улс үндэстний түвшинд хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх хууль тогтоомжийг бий болгох хэрэгжүүлэх улс орнуудын тоо өсөн нэмэгдсээр байна. Энэ чиг хандлага нь ялангуяа зөрчлийн дараах орнууд болох Косова, Босния Герзеговина гэх мэт улсуудын Эрүүгийн хуулийн шинэчлэлд тусгалаа олжээ.

Зарим улс орнуудад компанийн эрүүгийн хариуцлагыг эрүүгийн хуулиар биш иргэний болон захиргааны хуулиар авч хэрэгжүүлэх нь бий. Олон улсын гэрээ конвенцид ч үнэхээр эрүүгийн хуулийн үүргийг гүйцэтгэж байгаа тохиолдолд үүнийг хориглоогүй байдаг. Гэсэн хэдий боловч ихэнх судлаачид иргэний болон захиргааны хариуцлагын үр нөлөөг эрүүгийн хариуцлагаас сул гэж үзэж байна.

Тав. Монгол улс хуулийн этгээдэд оногдуулж буй хариуцлагын эрх зүйн зохицуулалт, өнөөгийн байдал, хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх шаардлагын талаар

Өмнө дурдсанчлан манай улс Эрүүгийн хуулийн ерөнхий ангидaa “Эрүүгийн хариуцлагыг зөвхөн хувь хүнд хүлээлгэн.” гэж заасан нь хувь хүнээс бусад байгууллага, аж ахуйн нэгж субъект болохгүй гэсэн утгыг илэрхийлж, хуулийн этгээдийг эрүүгийн хариуцлагын гадна үлдээж байна. Тиймээс хуулийн этгээдэд захиргааны хариуцлага л хүлээлгэж байгаа юм. Гэтэл Монгол улсад захиргааны хариуцлагын тогтолцоо сүл хариуцлага тооцох арга механизм алдагдсан боловсронгуй бус байдал. Хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэдэггүй энэ байдал нь сүүлийн жилүүдэд тэдний үйлдсэн гэмт хэргийн тоо ихсэхэд нөлөөлсөөр байна. 1992 оны Захиргааны хариуцлагын тухай хуульд зөрчил гаргасан хуулийн этгээдэд оногдуулах шийтгэлийн төрөл, хэмжээг дараахт байдлаар хуульчилсан.



ЭРҮҮГИЙН БАЙЦААН ШИЙТГЭХ ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

МӨРДӨН БАЙЦААЛТЫН НУУЦЛАЛ БА МЭДЭЭЛЭЛ АВАХ ЭРХ



XXI зуунд хүн төрөлхтний хамгийн үнэ цэнэтэй зүйл нь хүний эрх, эрх чөлөө нь болохыг дэлхий нийтээр хүлээн зөвшөөрч хүний эрхэд суурисан хөгжлийн үзэл баримтлалыг мөрдөх болсон билээ.

Иймээс иргэний эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах тухай асуудал нь төрийн бодлогоор эрх зүйн зохицуулалт, хамгаалалт хийхийг шаардаж байдаг.

Иргэн, төр, түүний байгууллагаас “тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй” асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй¹ хэмээн хуульчилсан Үндсэн хуулийн заалт нь иргэний үндсэн эрх, эрх чөлөөний нийтлэг байдлыг илэрхийлж байгаа төдийгүй иргэдээс мэдээлэл хайх, олж авах, ашиглах тусгайлсан эрх бий болгоход чиглэгдсэн эрх зүйн үндэслэл юм.

Мэдээлэл хайх, олж авах ажиллагаа нь мэдээллийг чөлөөтэй хүртэх, хязгаарлалтай хүртэх гэсэн 2 зарчмаар явагддаг.

Ийнхүү хязгаарлалтай хүртэх

ХСИС-ийн Цагдаагийн сургуулийн ЭБШЭЗ-н тэнхимиийн эрхлэгч, доктор, дэд профессор, цагдаагийн хурандаа Т.Оюунчимэг

“Гэмгүй хүний гэмт хэрэгтэн болгох, гэмт этгээдийг “гэмгүй” болгох эрх хэнд ч байхгүй”
И.И. Карпец.

мэдээллийн нэг нь мөрдөн байцаалтын нууцлалын тухай асуудал юм.

Монгол улсын иргэний Үндсэн хуулиар хамгаалагдсан эрх, эрх чөлөө, амь нас, эрүүлмэнд, өмчлөх эрхийг зөрчихөөс хамгаалах, зөрчигдсөн тохиолдолд сэргээн эдлүүлэх, тийнхүү зөрчсөн этгээдийн гэм бурууг нотолж тогтоох нь төрийн үүрэг бөгөөд төрийн чиг үүргийг гүйцэтгэх байгууллага болох хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, прокурор, шүүх, өмгөөлөлийн байгууллагууд хуулиар зөвшөөрөгдсөн бүхий л арга хэрэгслээр хэрэгжүүлнэ.

Гэмт хэрэг болон түүнийг үйлдсэн этгээдийн гэм бурууг нотлох ажиллагаа нь мөрдөн байцаалт явуулах замаар тогтоогдох бөгөөд энэ ажиллагааны явцад Үндсэн хууль, бусад хуулиар хамгаалагдсан, төр, байгууллага, иргэний халдашгүй, чөлөөтэй байх эрх, тэдний хуулиар хамгаалагдсан нууцыг хамгаалах тухай заалтыг чанд мөрдөх үүрэгтэй.

Өөрөөр хэлбэл Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд заасанчилан аливаа хүн эрх, эрх чөлөөгөө өдлэхдээ үндэсний аюулгүй байдал, бусад хүний эрх, эрх чөлөөг хохироож, нийгмийн дэг журмыг гажуудуулж болохгүй байдагчилан “Шүүхийн шийтгэх тогтоол гарах хүртэл хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэмт буруутайд тооцохгүй”

байх зарчим нь төрийн болон төрийн бус байгууллагуудын үйл ажиллагааны эрх зүйн үндсийг бүрдүүлж байдаг.

Мэдээлэлийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуульд: “Мөрдөн байцаалтын явцад төр, байгууллага, хувь хүний нууцыг хамгаалах шаардлагатай бол тухайн мэдээллийг бусдад задруулахыг хориглоно”² гэж хуульчилсан бол Монгол Улсын ЭБШ хуульд “Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын материалыг гагцхүү прокурорын зөвшөөрснөөр, түүний бололцоотой гэж гэж үзсэн хэмжээгээр нийтэд мэдэгдэж болох” тухай заалт бий /189 дүгээр зүйлийн 189.1. дэх хэсэг/.

Прокурорын зөвшөөрлөөр өгч болох мэдээллийн тухайд УДШ-ээс гаргасан тайлбарыг агуулгаар нь авч үзвэл хэргийн тухай нийтэд түгээх мэдээлэл нь:

- хүчирхийлэл, садар самууныг сурталчлахгүй байх,
- гэмт хэрэг үйлдэх сэдлийг төрүүлэхээргүй байх,
- гэмт хэрэг үйлдэх аргачлал болохооргүй байх,
- нийгмийн дунд айdas түгшүүр төрүүлэхээргүй байх,
- төр, байгууллага, хувь хүний нууцыг задруулахааргүй байх тухай тусгасан байх тухай байна.

¹Монгол Улсын Үндсэн хууль. 16 дугаар зүйлийн 17 дахь хэсэг. Төрийн мэдээлэл. 2002. № 6

²Мэдээлэлийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль. 18.1.3.



ХАЛААСНЫ ХУЛГАЙН ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭХ ТАКТИКИЙН ЗАРИМ АСУУДАЛ



Монгол улсад үйлдэгдэж буй гэмт хэргийн бүтцэд өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн, ялангуяа халаасны хулгайн гэмт хэргийн эзлэх хувийн жин өсч, нийгмийн хор аюул нь нэмэгдсээр байгаа болохыг дараах статистик мэдээнээс үзэж болно. 2012 онд цагдаагийн байгууллагад халаасны хулгайн гэмт хэргэг 249 бүртгэгдэж байсан бол 2013 онд 426 болж даруй 177 гэмт хэргээр өссөн үзүүлэлттэй байна.¹ Иймд цагдаагийн албан хаагч нь халаасны хулгайн гэмт хэргийг үйлдэж буй этгээд, тэдний үйлдлийн арга, сэтгэл зүйн онцлог зэргийн талаар өндөр мэдлэгтэй, тэмцэх арга зүйг бүрэн эзэмшсэн, сонор сэргэж, ёс зүйтэй, өндөр сахилга баттай байх ёстой.

Цагдаагийн албан хаагч / халаасны хулгайн гэмт хэргтэй тэмцэх чиг үүрэг бүхий төлөөлөгч, туслах төлөөлөгч/энэ төрлийн гэмт хэргтэй тэмцэхдээ дараах зүйлд анхаарвал зохино. Үүнд:

1. Төлөөлөгч нар олны дунд биеэ авч явахдаа анхаарах зүйл

Төлөөлөгч нар гудамж талбай, олон нийтийн газар явахдаа аль болоххүний хараанд өртөхгүй содон биш энгийн хувцас

¹ Цагдаагийн ерөнхий газрын Мэдээлэл, судалгааны төв. Монгол улс дахь гэмт хэргэг, захиргааны зорчлийн нөхцөл байдал. УБ., 2014. 169 дэх тал

Т.Болор-Эрдэнэ
ХСИС-ийн Захирлын даалгавар гүйцэтгэгч,
цагдаагийн дэслэгч

өмсөж албан үүргээ гүйцэтгэх шаардлагатай. Хоёроос дээш төлөөлөгч хамт явах тохиолдолд аль болох албан яриаг цөөлөх, өөр хоорондоо тодорхой хэмжээний зйтай, хоорондоо угсэн тохирсон дохио зангаатай байх нь чухал.

Хэрэв ямар нэгэн сэжигтэн этгээдтэй хаанэггазартааралдсан тохиолдолд ганцаар байгаа байдлыг харагдуулах, бусад төлөөлөгч нь алсаас ажиглалт хийх, зүс царай хувцаслалт, хэдүүлээ явж байгааг тогтоох зэрэг ажлыг гүйцэтгэх ба уулзаж буй төлөөлөгч элдэв яриаг өдөж яриулах гэмт хэргийн шинжтэй яриаг тогтоож, шууд захирах даргадаа илтгэх хуудсаар илтгэж байвал зохино.

Гудамж талбайд найз нөхөдтэйгээ таарсан үед аль болох удаан уулзаж зогсохгүйг хичээн, ямар нэгэн шалтгаан гаргаж тухайн газраас холдох арга хэмжээг авах нь зүйтэй.

Төлөөлөгч олон нийтийн газар албан ажлын талаар сонирхуулан ярих, хамт үүрэг гүйцэтгэж буй төлөөлөгчдөө танилцуулах, албаны холбогдолтой эд материал, нэг бурийн хэрэгсэл, үнэмлэх зэргийг үзүүлэхийг хориглоно. Үзвэр, үйлчилгээний газар хүмүүстэй аль болох боловсон, соёлтой харьцаж, цагдаагийн ажилтан гэдгээ мэдэгдэхгүй харьцах нь чухал юм.

2. Сэжигтэй этгээдийг дагах, ажиглахад анхаарах зүйл

Төлөөлөгч олон нийтийн газар үүргээ гүйцэтгэж байхдаа сэжигтэй этгээдийг олж илрүүлсэн, ямар нэг сэжигтэй эд зүйл авч яваа сэжигтэн этгээдийг араас дагах тохиолдолд албаны

нууцлалыг маш чанд сахиж, ямар ч тохиолдолд сэжиг авахуулахгүй байх талаар анхаарвал зохино. Үүнд:

- Гадаад үзэмж хувцаслалт маш энгийн, цагдаагийн ямар нэгэн дүрэмт хувцас, хэрэгсэл өмсөхгүй байх

- Ой тогтоолт сайн байх. Тухайлбал, явах маршрут, очих хаяг, авч яваа эд зүйлийн онцлог, сэжигтний хувцаслалт, биеийн галбир төрх, зүс царай, хамсаатнуудын талаар тогтоох хэрэгтэй.

- Харааны сайн байх. Төлөөлөгч алсаас ажиглах, сэжигтэй этгээдийгнүд салгахгүй харах чадварыг эзэмших хэрэгтэй. Ялангуяа сэжигтнүүдийн үйл хөдөлгөөнд ныхн гярхай ажиглалтыг хийж сурх хэрэгтэй.

- Төлөөлөгч өөрийн биеийг зөв авч явахад анхаарах. Сэжигтэн болон тухайн сэжигтэй эд зүйлийг шимтэн харах, төвлөрүүлэн ажиглах нь сэжиг төрүүллэг учир аль болох алсын зайнаас харж хянах, боломжгүй бол ойртон очиходо ямар нэг өөр аргаар /хажуугаар өнгөрсөн хүн болох, санаандгүй тааралдсан хүн болох, цаг асуух, согтуу дүр үзүүлэх гэх мэт/ ажиглалтыг хийж болно.

- Араас нь дагаж хянах явцад газар орны байршил, цаг агаарыг ажиглан өөрийгөө өнгөлөн далдлах, биеэ хамгаалах бусдын хараанд өртөхгүй байхыг хичээх хэрэгтэй. Тухайлбал, Их нартай өдөр сэжигтний сүүдрийн эсрэг талд гарч явахад сэжигтэнд нар гялбаад эсрэг хүнээ сайн харж чадахгүй. Автобусанд хойд урд хаалганы дэргэд зогсож явахад мөн шөнийн цагт гэрлээс хол явах ашигтай. Хэрэв 2-3



гэмт этгээд биедээ элдэв хутга мэс авч явж болзошгүй бөгөөд сэжигтэн этгээдийн гар нь дээр байгаа тохиолдолд тухайн зэвсэг, эд зүйлээ биеэсээ салгах, авах, зугтах нөхцлийг хязгаарлаж өгдөг. Хөлийг нь мөрнөөс илүү хэмжээтэй зйтай зогсоосон үед сэжигтэн зугтах тохиолдолд гэнэтийн хөдөлгөөн хийх нь тодорхой хэмжээгээр удааширагдаг.

• Сэжигтний халаасанд маш болгоомжтойузлэг хийх нь хэрэгтэй. Халаасны хулгайн гэмт хэрэг үйлддэг сэжигтэн нар цүнх, тор, сав зүсэх зориулалттайгаар биедээ цаасны болон сахлын хутга авч явдаг тул цагдаагийн албахаагч гараа зүсэх, гэмтээх тохиолдол их гардаг. Зарим тохиолдолд сэжигтэн нар өөрсдийн хувцасны халаасны буланд нууц газар зүсч онгорхой зайд гарган түүндээ хулгайн эд зүйлээ хийж нуудаг, үзлэг нэгжлэг хийхэд хулгайн эд зүйл нь гардаггүй, олддоггүй, үнэн чанартга хулгайн эд зүйл, мөнгө нь пальто, хүрэм болон бусад хувцасны дотор талын доод хэсэгт хормойд нь хадгалагдаж үлддэг тохиолдол бий.

• Сэжигтэнд үзлэг хийх явцад хохирчийн мөнгө, эд зүйл гарах тохиолдолд заавал өөрт нь нүдэн дээр нь болж өгвөл хохирогчийг хажууд нь байлгаж байгаад гарган үзүүлж хураан авч, тэмдэглэл хөтлөх бололцоогүй бол хохирогчийн мөнгө, эд зүйлийг ил харагдахаар барьж яваад, ажил дээрээ ирж хураан авсан тэмдэглэл хөтөлж болно. Учир нь сэжигтэн нар “Би хулгайлсан эд зүйл, мөнгөө сайн мэдэхгүй, хараагүй, тоолж үзээгүй, шууд баригдсан, юу байсныг мэдэхгүй, та нар мөнгө нэмж хийгээд намайг яллах гэж байна” гэж эсэргүүцдэг, нөгөө талаар хохирогч мөнгөө алдсан тохиолдолд хохирлоо нэмж хэлж, их мөнгө, эд зүйл байсан гэж нэхэмжлэх тохиолдол гардаг. Үүнд туслах төлөөлөгч нар маш хяналгай хандах нь зүйтэй. Үзлэг

хийх үед сэжигтэн нарыг илүү дутуу хөдөлгөөн хийлгэх, үзлэгийн дараа өрөө тасалгаа, үүдний хонгилд холхиулахгүй байлгахад анхаарах хэрэгтэй. Үзлэгийг бүрэн гүйцэд хийх шаардлагатай. Дутуу хийснээс хохирогчийн эд зүйл, мөнгө дутах эсвэл хулгайн эд зүйл, мөнгө гарч ирэхгүй байх тохиолдол бий болдог.

• Сэжигтэн нартай харьцаадаа тухайн хүний зан ааш, хүмүүжил, нүдний харц, гадна төрхөнд нь таарах “түлхүүр”-ийг нь олжхарыцах хэрэгтэй. Дөлгөөн тайван аймхай, намуун харцтай, удаан зөвлөн яриатай хүнтэй яг тэр байдлаар нь, ууртай хурц ширүүн зантай хүнтэй хуулийн дагуу сэтгэл зүйн нөлөөллийг үзүүлэн илүү давамгайлах маягаар харьцвал үр дүнд хүрэх талтай. Сэжигтэн нартай харьцах, хэргийн холбогдоор тайлбар, байцаалт авах үед ер нь ямар ч нөхцөлд хэрэг бүртгэгч, төлөөлөгч, туслахтөлөөлөгч нар тэд нараас илүү мэдлэгтэй, байнгын сэтгэл зүйн нөлөө үзүүлэх чадвартай, тэднийг өөрийн эрхгүй яриулах уг алдуулах арга барилыг эзэмшсэн байх хэрэгтэй.

Сэжигтэн нарын аргийн байдал эцэг эх, ах дүү, эхнэр нөхөр, үр хүүхэд, амьдралын нөхцөл, оршин суух газар, сонирхдог зүйл, нөхөрлөдөг найз нөхөд, хулгай хийхээр явдаг газар, чиглэл, үйлдлийг арга гэх мэт олон зүйлийг сайтар судлан мэдэж ой санамжиндаа шингээсэн байх хэрэгтэй.

Гэмт этгээдүүдмөнгөтэй түрийвч хулгайлсан тохиолдолд мөнгийг нь аваад бичиг баримтыг нь шууд хаядаг байсан бол одоо бичиг баримтыг нь ашиглах, элдэв барьцаанд тавих, цахим картуудыг ашиглан банкнаас бэлэн мөнгө авах, дэлгүүр, худалдаа, үйлчилгээний газруудаар үйлчлүүлэх болсон. Сүүлийн үед халаасны хулгайн

гэмт хэрэг үйлдэгч нар компьютер болон хэлний мэдлэгтэй болж байгаад анхаарч бид тэд нараас хоцрохгүй илүү сайн мэдлэг боловсролтой чадвартай болох нь шаардлагатай байна.

Халаасны хулгайн гэмт хэргийн гаралт тогтмол ёсч, үйлдлийн арга нь улам боловсронгуй болж байгаа нь нийгмийн хөгжил дэвшлээ дагаад сэжигтэн нарын сэтгэх ухаан, мэдрэмж тодорхой хэмжээгээр дээшилсэнтэй холбоотой. 2000 оноос өмнө халаасны хулгайн гэмт хэрэг үйлдэгчид автомашин хөлөглөн, гар утас барьж байгаагүй бол өнөөдөр өөрсдийн машин унаатай, хоорондоо харилцах утастай, төсвийн дундаж цалинтай албан хаагч нараас дутуугүй явах болжээ. Тэд дуртай газраа өөрсдийн автомашинаар шуурхай очиж, хоорондоо гар утсаар холбоо барьж, гэмт хэргээ үйлдээд хэргийн газраас түргэн зайллах болсон. Иймд энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэж байгаа цагдаагийн албан хаагчид, ялангуяа тэдэнтэй нүүр тулан ажилладаг туслах төлөөлөгч нар орчин үеийн холбооны хэрэгсэлтэй, сэтгэлгээ, мэдрэмжээ илүү ихээр хөгжүүлэн урьдчилан тооцохгэмт үйлдлийг илрүүлэх, тэмцэх чадвартай байх шаардлага тулгарч байна.

Халаасныхулгайн гэмт хэрэг үйлддэг этгээдүүд зохион байгуулалтанд орсон тул туслах төлөөлөгч нар хаана ямар бүлэг, ямар арга, үйлдлээр гэмт хэрэг үйлдэж байгааг урьдчилан мэдэх, сэжигтэн нартай зөв тактиктай харьцах, мэдээ мэдээлэл олж сонсох, баримтжуулах аж ахуйн нэгж, байгууллагын хяналтын камер ашиглан гэмт хэргийг цаг алдалгүй үйлдэл дээр болон нөхөн илрүүлэхийг хамгийн чухал зорилго болгон ажиллах хэрэгтэй.



ТАГНАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

ТАГНАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЭРХ ЗҮЙГ ХӨГЖҮҮЛЭХ АСУУДАЛ */Гүйцэтгэх ажлын тухай хууль тогтоомжийн хүрээнд/*



А. Хүн төрөлхтөн үүсэн бий болсон тэр цагаас эхлэн түүний оюун ухаан улам хөгжиж ирсээр өнөөгийн соёлт нийгэмтэй хөл нийлүүлэн алхаж байна. Улмаар хүний оюун ухааны тусламжтайгаар олон салбар шинжлэх ухаанд шинэ нээлт тэсрэлт болсоны нэг нь Тагнах үйл ажиллагааны эрх зүйн салбар шинжлэх ухаан юм.

Тагнах үйл ажиллагаа нь дэлхийн улс орнуудад нууц хэлбэрээр хөгжиж ирсэн бөгөөд үүнийг зөвхөн дайны үед ямар арга тактикаар тулалдахад ашиглаж байсан нь судлаачдын бүтээлд тусгалаа олсон байдаг. Их Монгол Улсын хаан Чингис өөрийн тагнуулч, туршуулуудын тусламжтайгаар өөрийн үйл ажиллагаагаа тухайн цаг үе, нөхцөл байдалд зөв хэрэглэснээр амжилтанд хүрсэн гэдэгт маргах нэгэн байхгүй билээ.¹ Үүнээс залгамжлан тагнах үйл ажиллагаа Монгол улсад хөгжиж ирсэн бөгөөд өнөөгийн байдлаар эрх зүйн салбар шинжлэх ухаан болон хөгжиж байна.

Бид Монгол Улсын тагнах үйл

*R.Bayarmagan
ХСИС-ийн Цагдаагийн сургуулийн Гүйцэтгэх ажлын тэнхимийн ахлах багш, цагдаагийн ахмад*

ажиллагааны эрх зүйг гадаадын зариморны тагнах үйл ажиллагааны эрх зүйтэй харьцуулан судалж, улмаар Монгол Улсын тагнах үйл ажиллагааны эрх зүйн салбар шинжлэх ухаанд тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэхийг судлахыг зориоо.

Зүүн Азийн цээжинд орших Монгол түмэн бид өөрсдийн гэсэн түүхэн хэв маягтай үндсээрхэг ард түмэн билээ. Улс орон бүр өөр өөрийн гэсэн тусгай гүйцэтгэх албадуудтай байдаг бөгөөд энэ нь тухайн улс орны өвөрмөц онцлогтой тохирсон байдаг. Тиймээс гүйцэтгэх албаны үйл ажиллагаа нь тухайн орны аюулгүй байдлыг хангах, болзошгүй дайсныхаа далд эрмэлзэл, аюул заналыг түүнд мэдэгдэлгүйгээр урьтан мэдэж, сэргийлэх, хамгаалах ажиллагааг явуулдаг.²

Хэдийгээр аль ч улсын тусгай алба тагнуулч, туршуул болон тагнуулын тусгай арга хэрэгсэл ашигладаг нийтлэг ижил төсөөтэй талуудтай ч тэдгээр нь өөр өөрийн гэсэн өвөрмөц онцлогтой. Тэдгээр онцлог нь тухайн улс орны нийгэм, эдийн засаг, улс орны газар зүйн тогтоц, улс төрийн дэглэм түүний тогтолцоо, Үндэсний аюулгүй байдлыг хангах цэрэг арми, тусгай албадын тогтолцоо зэргээрээ ялгагддаг байна.

Монгол Улсын тусгай албад түүний үйл ажиллагаа нь дээр дурьдсан зүйлээс ялгагдах онцлог байгаагүй бөгөөд монгол Улсын

тусгай албадын үүсэл хөгжил, үйл ажиллагаа нь Монгол Улсын түүхэн хөгжилтэй салшгүй холбоотой юм.

Монгол улсад тагнуулын үйл ажиллагаа хөгжиж ирсэн нь эртний улбаатай. Монгол угсаатны эртний хүчирхэг улс болох Нирун Улсын байлдаа арга, тактик, мэхийн тухай хятад эх сурвалжуудад “ХАРГУЛСАН” буюу тагнах зэрэг хэллэгийг тэмдэглэсэн” гэж Монголын түүх судлаачид үзсэн байдаг.³

Их Монгол улсад тагнуулын үйл ажиллагаа хөгжих болсон үндэслэлийг дараах байдлаар тайлбарлаж болно. Үүнд:

□ Монгол Улсын гадаад нөхцөл байдал

- Хөрш зэргэлдээ улс орны зөрчил тэмцэл
- Дайн байлдааны арга хэрэгсэлд суралцах

- Дайдах гэж байгаа улс орны нийгэмт улс төрийн өвөрмөц байдлыг тандаж мэдэх

▪ Гадаад улс орноос явуулж байгаа цэргийн далд бодлого

□ Монгол Улсын дотоод нөхцөл байдал

- Нэгдсэн ханлиг аймгуудын доторх тэмцэлдээн
- Хаан ширээ эд хөрөнгийн тэмцэл маргаан⁴

Гадаадаас Монголчуудад учрах аюул занал мундахгүй байсан бөгөөд 1130-аад онд Хабул хаантай Хамаг Монгол улс байгуулагдаж, түүний хаанчлах хугацаанд Алтан Улс Хамаг Монгол Улсыг Цэргээр

¹ Мятаавын Цогтоо., Их Монгол Улсын тагнуулын үйл ажиллагаа. УБ. 2008. 6 дахь тал.,

² Очерки, внешней разведки, под., редакции., академиком., Е.М. Примаковым. Москва., 1986., с-13.,

³ Т.Сүхбаатар. “Их Нирун Улс. УБ. 1992., 108-р тал

⁴ М.Цогтоо. Их Монгол Улсын тагнуулын үйл ажиллагаа. УБ., 2008. 6-дугаар тал



хамгаалахтай холбоотой үйл ажиллагаанд оролцох эрх олгосон олон хуулийн заалт, “Үндэсний аюулгүй байдлыг тагнуулын аргаар хангана” гэсэн Тагнуулын байгууллагын тухай хуулийн 4.1 дэх заалтыг хэрэгжүүлэхтэй холбогдсон тус байгууллагын үйл ажиллагаанд чиг баримжаяа болох Үндсэн хуулийн Үндэсний аюулгүй байдалд холбогдох заалт, түүнчлэн үндэсний аюулгүй байдлыг хангах үүрэг бүхий төрийн байгууллагын чиг үүрэгтэй уялдаа холбоотой манай байгууллагын үйл ажиллагаанд холбогдох хуулиуд, тагнуулын байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүрэгтэй Хууль Тогтоох Дээд Байгууллага, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Монгол улсын Ерөнхийлөгчийн тухай, Засгийн газрын тухай, Монгол улсын прокурорын тухай хуулиудын заалтыг оролцуулан тооцвол 30 шахам хуулийг Монгол Улсын хууль тогтоох дээд байгууллага 1992 оноос эдүгээ хүртэлх 20 жилийн хугацаанд батлан гаргасан байна¹⁰.

Тагнуулын ба гүйцэтгэх ажлын тухай хэм хэмжээний актын системд, тагнуулын ба гүйцэтгэх ажил явуулах эрх бүхий байгууллагын тагнуулын ба гүйцэтгэх ажлын зохион байгуулалтын ба тактикийн асуудлаар гаргасан нууц тушаал, заавар багтдаг. Эдгээр акт тагнуулын ба гүйцэтгэх ажлын байгууллагуудад “Гүйцэтгэх ажлын тухай хууль”-аар олгосон эрх хэмжээний дагуу явуулах гүйцэтгэх ажлын арга хэмжээний агуулга, арга хэмжээний үр дүнг баримттай болгох, тагнуулын ба гүйцэтгэх ажил явуулдаг байгууллагын удирдлагын эрх хэмжээ, гэрээ байгуулж буюу гэрээ байгуулахгүйгээр иргэнийг нууц хамтын ажиллагаанд татан оруулах асуудлыг тодорхой болгож

өгдөг¹¹.

Тагнах ажиллагаа гэхээр ард иргэд Сөрөх тагнуул, Дотоодын тагнуулын мэдээлэл цуглувудаг хүмүүс гэсэн ойлголттой байдаг. Гэтэл Монгол Улсад гүйцэтгэх ажил явуулдаг 6 байгууллага хуульд заасан үндэслэл, журмын дагуу бүгд өөр өөрийн чиглэлийн тагнуулын үйл ажиллагааг явуулсаар өнөөдрийг хүрсэн.

Цагдаагийн байгууллага гүйцэтгэх ажлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1-д зааснаас бусад далд аргаар үйлдэгдсэн, эсхүл тодорхой гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоо, түүнийг үйлдсэн этгээдийг олж тогтоох, түүнчлэн сураггүй алга болсон, нас барсанд тооцогдсон хүн, оргосон сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтан болон прокурор, шүүхээс даалгасан бусад хүнийг эрэн сурвалжлах, алдагдсан галт зэвсэг, сум хэрэгсэл, тэсэрч дэлбэрэх, мансууруулах, хордуулах бодис, түүх соёлын дурсгалт болон бусад үнэт зүйлийг эрж олох¹² зорилгоор гүйцэтгэх ажил явуулдаг.

Иргэдийн дунд явуулсан судалгааны тайлангаас үзэхдэд тагнах үйл ажиллагааны эрх зүйн талаар иргэд ойлголтгүй, мөн түүнчлэн эрх зүйн чиглэлээр бакалаврын боловсрол олгож буй их, дээд сургуулийн оюутнуудын дунд хийсэн судалгаанаас энэ салбар эрх зүйг мэдэхгүй, энэ чиглэлийн хичээл сургалтын хөтөлбөрт байхгүйн улмаас ордоггүй гэсэн хариултыг өгсөн нь анхаарал татаж байна.

Эдгээр эрх зүйн чиглэлээр суралцагсад их, дээд сургуулиа төгсөөд хуульч, өмгөөлөгч, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгч болдог бөгөөд гүйцэтгэх алба ажилтантай хамтран ажиллах талаар анхан шатны ойлголт байхгүй байгаа нь нууц далд аргаар үйлдэгдсэн гэмт

хэргийг илрүүлэх таслан зогсоох, урьдчилан сэргийлэх ажилд саад учирч байна.

Манай улсын хувьд гүйцэтгэх албны үйл ажиллагаа, эрх зүйн зохицуулалт нь нууц байдаг нь ард иргэдэд ойлголтгүй, хаана хэнтэй яж хамтран ажиллахаа мэдэхгүй, мэдсэн ч мэдээгүй дүр үзүүлэх явдал тулгамдаж байна. Ингэснээр гэмт хэргийг халуун мөрөөр нь шуурхай илрүүлэх, урьдчилан сэргийлэхдэд чөдөр тушаа болдог.

Гадаадын зарим улс орнуудын хувьд гүйцэтгэх албаны үйл ажиллагаа, энэ чиглэлийн ном, сурх бичиг нь ил /нууцын зэрэглэлгүй/ байдаг бөгөөд ердийн худалдаанд зарагдаж байхад манай улсын хувьд маш нууцын зэрэглэлд хамааруулсан байдаг. Тухайлбал, ОХУ-ын ДЯЯ-ны гүйцэтгэх ажлын заавар, дүрэм журам нь нийтэд ил тод байдаг ба харин ХЭНИЙГ ХЭЗЭЭ, ХААНА гэдэг нь маш нууцын зэрэглэлд байдаг. Ингэснээр гүйцэтгэх ажил явуулсан цуглувулсан нотлох баримт нь хуульд заасан үндэслэл, журмын дагуу шүүх дээр нотлох баримт болдог байна.

Харин Монгол Улсын хувьд Гүйцэтгэх ажлын тухай хууль нь ил боловч түүнийг хэрэгжүүлэх процессын хууль үгүйлэгдэж байна. Иймээс гүйцэтгэх ажилтны олж цуглувулсан эд мөрийн баримт нь шүүх хуралдаанд нотлох баримтын хэмжээнд үнэлэгдэхгүй байгаагас сэжигтэн, яллагдагч нар ял завших, иргэд цагдаагийн байгууллагад итгэх итгэл буурч байна гэж бид үзэж байна.

Тагнуулын байгууллага, түүний ажилтнууд өнөө үед үндэсний аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий төрийн бусад байгууллагуудтай нягт холбоотойгоор ажиллаж, ард иргэдийн туслалцааг авч үйл ажиллагааг явуулах, тэдэнд туслалцаа үзүүлэх боломж олгосон хуулиудын заалтуудыг сайтар судалж, мэдэж ажилдаа хэрэгжүүлэх зайлшгүй

¹⁰Л.Батдолгор, С.Жаргалсайхан. Гүйцэтгэх ажил ба эрх зүйн зохицуулалтын зарим асуудал.УБ.2007, 62 дугаар тал.

¹¹Л.Батдолгор, С.Жаргалсайхан. Гүйцэтгэх ажил ба эрх зүйн зохицуулалтын зарим асуудал.УБ.2007, 61 дүгээр тал.
¹²Гүйцэтгэх ажлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3



болон өргөжсөн түүхтэй.

Тус хэлтэс 1960-1965 онд хот хөдөөгийн хэмжээгээр хэв хурам сахиулах ажлыг хариуцаж, Нийслэлийн 13 хороо, аймгийн цагдан сэргийлэх ангийн сэргийлэн хамгаалах байцаагч, хотын хороо бүр нэг сэргийлэгчтэйгээр хэв журам сахиулж байв.¹

1963 онд батлагдсан БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 499 тоот тогтоолоор батлагдсан “БНМАУ-ын Цагдан сэргийлэх байгууллагын дүрэм”² –д зааснаар тухай үеийн Цагдан сэргийлэх байгууллагад:

- Гэмт хэрэгтэй тэмцэх талаар
- Олон нийтийн хэв журам сахиулах талаар
- Хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах талаар
- Галын аюулаас хамгаалах талаар
- Паспортын дурмийг биелүүлэх талаар
- Иргэний гэр бүлийн байдлыг бүртгэх талаар
- Бусад үүргийн талаар гэсэн зохицуулалттайгаар нийтдээ 7 салбар чиг үүргийг дурмээр хүлээлгэж байсан байна.

Энэ дүрэмд заагдсан “Олон нийтийн хэв журам сахиулах” үүрэгт зааснаар танхайрагчид, ажил хөдөлмөргүй хүмүүс, хараа хяналтгүй хүүхэд, архичин согтуутай тэмцэх ажлыг эрчимжүүлэх ажлын хүрээнд тусгайлан тэмцэх албыг байгуулах шаардлага тухайн цаг үед бий болсныг харгалзан 1970 онд УЦСЕГ-ын гүйцэтгэх албаны хэлтсээс сэргийлэн хамгаалах албыг салгаж, УЦСЕГ-ын бие даасан хэлтэс байгуулсан байна.

¹А.Думбурай. Монгол төрийн цагдаагийн уламжлал, түүхэн хөгжилт. УБ. 1999. 38 дахь тал

²Т.Хүрэлбаатар. Монголын цагдаагийн байгууллагын түүхийн зарим баримт бичгүүд. УБ. 2011. 67 дахь тал. 1963 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 499 тоот тогтоолоор “БНМАУ-ын Цагдан сэргийлэх байгууллагын дүрэм ба тангарагийн үгийг батлах тухай” баталж байсан байна.

1970-аад оны дундуур Нийслэлийн районы цагдан сэргийлэх хэлтсүүдэд сэргийлэн хамгаалах ахлах байцаагчид, орон сууцны гудамж хорооны 50 гаруй байцаагч, 100 гаруй сэргийлэгчтэй болж, хэв журам сахиулах ажил өргөжсөн нь тухайн үед гэмт хэрэг, зөрчил өсөх хандлагатай болсон холбоотой байна.

Энэ нь нийслэлийн хүн ам жил ирэх тусам өсөж, захиргаа, лабораторийн тоног төхөөрөмж, хэргийн газрын үзлэгийн цүнх, магнитфон, диктафон, бичгийн машин зэрэг техник хэрэгсэл авч байв.³

1975 онд Улаанбаатар хотын харьяа дүүргүүдийн цагдан сэргийлэх хэлтэст сэргийлэн хамгаалах ахлах болон орон сууц, гудамж болон хороод хариуцсан хэсгийн байцаагч гэдэг албан тушаалыг анх удаа бий болгож 50 гаруй байцаагч, 100 гаруй сэргийлэгч ажиллуулж, хөдөө орон нутагт, засаг захиргааны 3-5 нэгж хариуцсан хэсгийн төлөөлөгчийн ажлын зохион байгуулалтыг өөрчлөн, 1970 оноос эхлэн сум бүрт хэсгийн төлөөлөгчтэй болов.⁴

Улаанбаатар хотын Цагдан сэргийлэх газар нь Сэргийлэн хамгаалах гарнизон дотроо урьдчилан сэргийлэх хэлтэс, хэв журам сахиулах тасаг харуулын тасаг, эргүүл, харуулын хэд хэдэн роттой ажиллаж, Цагдан сэргийлэх байгууллагын харьяа аймаг, хотын районы Цагдан сэргийлэх хэлтсүүд сэргийлэн хамгаалах тасаг, ахлах жинхэнэ байцаагч, хэсгийн байцаагч, хорооны сэргийлэгчтэй ажиллаж, энэ албыг УЦСЕГ-ын 1-р

³А.Думбурай. Монгол төрийн цагдаагийн уламжлал, түүхэн хөгжилт. УБ. 1999. 114-115 дахь тал

⁴“Монгол Улсын Цагдаагийн байгууллагын түүхэн замнал, шинэтгэл”. Эрдэм шинжилгээний бага хурлын эмхтгэл. УБ. 2006. 32 дахь тал. Ж.Долгорцүрэн “Ардын хувьсгал, хөрөнгөтний бус хөгжлийн болон социализм байгуулахаар замнасан үеийн Монголын Цагдан сэргийлэх байгууллагын эрх зүйн зохицуулалт, зохион байгуулалтын бүтцийн онцлог” сэдвээр тавьсан илтгэлээс хэсэгчилэн авав.

орлогч дарга хариуцан ажиллаж байжээ.⁵

Нийслэл хотод хэв журам сахиулах ажил нэгдсэн байршлын системээр зохион байгуулан боловсронгуй болгож, райлны хороодод хэсгийн байцаагчийн систем нэвтэрч, эргүүл ба хорооны сэргийлэгчдийн хүчийг зарим газар төвлөрүүлэн тодорхой нэг путект байрлуулж, эргэн тойрноо хариуцан ажиллаж байсан байна.

1980-аад оны дунд үеэс, хөдөө орон нутгийн сум, багт, хот суурин газрын орон сууц, хороодод ажиллаж байгаа цагдаагийн орон тоог дахин нэмэгдүүлж, төрөл бүрийн дэс дараатай олон хэлбэрийн ажлыг зохион байгуулж эхэлснээрээ гэмт хэрэг, зөрчлийн гаралт буурч, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын эрч далайц эрс нэмэгдсэн байна.

Тухайн үед Цагдан сэргийлэх байгууллагын төрөл мэргэжлийн олон албад материаллаг баазаа бэхжүүлж байсны заримаас дурдвал хэв журам хамгаалах чиглэлээр радио холбоо, дохиолол хамгаалал, шинжлэх ухаан, техникийн олон багаж, хэрэгсэл, төхөөрөмжийг ЗХУ-аас ихэвчлэн оруулж ирэн практикт өргөнөөр нэвтрүүлж байсан нь саяхан билээ.

1985 оны 04 дүгээр сарын 26-ны Сайд нарын Зөвлөлөөс “БНМАУ-ын цагдан сэргийлэх байгууллагын дүрэм”⁶-ийг 6 бүлэг, 32 зүйлтэйгээр батлан гаргасан нь сэргийлэн хамгаалах албаны харьяанд ажиллаж байгаа хэсгийн байцаагч нарын үйл ажиллагаа өргөн хүрээтэй болж өргөжих эхэлсэн гэж үзэж болно.

БНМАУ-ын Бага Хурлаас 1990 оны 10 сарын 5-ны өдөр “Цагдан сэргийлэх, засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн байгууллагын ажилтнаас үүргээ биелүүлэх баталгааны тухай” буулийг батлан

⁵А.Думбурай. Монгол төрийн цагдаагийн уламжлал, түүхэн хөгжилт. УБ. 1999. 232 дахь тал

⁶Т.Хүрэлбаатар. Монголын цагдаагийн байгууллагын түүхийн зарим баримт бичгүүд. УБ. 2011. 67 дахь тал.



актыг үндэслэн үйл ажиллагаа явуулдаг нь хэсгийн байцаагчийн үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтын онцлог юм.

Зөвхөн “Хэсгийн байцаагчийн ажлын заавар”-т зааснаархэсгийн байцаагч нь, гэмт хэрэгтэй тэмцэх, илрүүлэх, нийгмийн хэв журам хамгаалах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 8, Цагдаа-олон нийтийн хамтын ажиллагааны чиглэлээр 5 үүргийг гүйцэтгүүлэхээр тусгасан.

Энэ бүхнээс үзэхд хэсгийн байцаагч нь цагдаагийн байгууллагын зорилт, чиг үүргийг

хангах 33 үүргийг хүлээдэг бөгөөд гэмт хэрэгтэй тэмцэх, илрүүлэх чиглэлээр 7, Нийгмийн хэв журам хамгаалах чиглэлээр 13, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 8, Цагдаа-олон нийтийн хамтын ажиллагааны чиглэлээр 5 үүргийг гүйцэтгүүлэхээр тусгасан.

орон нутагт хэрэгжүүлж байгаа чухал албан тушаалтан бөгөөд өөрийн үйл ажиллагааг тухайн нутаг дэвсгэрийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын өмнө хариуцан тайлагнаж, оршин суугаа газрынхаа хүн амд ажлын үр дүнгийн талаар тайлангаа тавьдаг онцлогтой албан тушаалтан юм.

ЦАГДААГИЙН АЛБАН ХААГЧ НЬ ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ДОТООД АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ҮНДСЭН ХҮЧ МӨН



Д.Булган

ХСИС-ийн Цагдаагийн сургуулийн Цагдаагийн эрх зүйн тэнхимийн багши, цагдаагийн ахмад

хөгжлийн зорилтод сууриссан үндэсний хөгжлийн цогц бодлого”-д “Төрийн үйлчилгээг хүртээмжтэй, ил тод болгох, хүний эрхийг баталгаатай хангах, нийгэм дэх аюулгүй орчныг бий болгох эрх зүйн зохицуулалтыг тус тус боловсронгуй болгоно”, 2012 оны 37 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т “шүүх, хууль хяналтын байгууллагын тогтолцооны шинэчлэлт хийх”-ээр тус тус тусгасан.

Засгийн газрийн үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт хууль зүйн бодлогыг шинжлэх ухааны үндэстэй, хүний эрх, эрх зүйт ёсны зарчимд нийцүүлэх механизмыг бий болгохоор заасан ба уг хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд эрх зүйн шинэтгэлийн баримт бичиг боловсруулах зорилт тавьсан нь биелэлээ олж эхлэлээ.

Энэхүү эрх зүйн шинэтгэлийн хүрээнд хийгдэж буй “Цагдаагийн албаны тухай хууль” 2013 оны 07 сарын 05-нд батлагдан гарсан бөгөөд энэ хуулиар “Цагдаагийн алба” гэдэг нь гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үндсэн чиг үүрэг

бүхий хууль сахиулах байгууллага мөн гэж тодорхойлоод нилээд онцлогтой хэд хэдэн заалтууд оржээ. Тухайлбал, цагдаагийн байгууллагын зохион байгуулалтын бүтцийн хувьд нилээд өөрчлөлттэй цагдаагийн албаны тухай хуульдийн 5 дугаар зүйлийн 3-т “Цагдаагийн төв байгууллага нь гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах болон дэмжлэг үзүүлэх зохион байгуулалтын бүтцийн нэгжээс бүрдэнэ²”. Ийнхүү цагдаагийн төв байгууллагад дотоод хяналт-аюулгүй байдлын нэгж байгуулахаар заасан бөгөөд энэ нь эрх зүйн зохицуулалтын хувьд шинэлэг зүйл юм.

Цагдаагийн нийт байгууллага, алба хаагчийн үйл ажиллагаанд хяналт тавьж, алба хаагч, ажилтныг гэмт хэрэг, зөрчил үйлдэх, ёс зүй, сахилгын зөрчил гаргах явдалтай тэмцэх, шалтгаан нөхцлийг арилгах арга хэмжээ авч цагдаагийн албаны дотоод хяналт-аюулгүй байдлыг хангахаар талаар тусгав.

Нэг. Цагдаагийн албаны дотоод-аюулгүй байдлын тухайд
Монгол Улсын Үндэсний

Монгол Улсын Үндсэн хуулийн оршилд “Монголын ард түмэн бид: улсынхаа тусгаар тогтнол, бүрэн эрхэт байдлыг бататган бэхжүүлж, хүний эрх, эрх чөлөө, шударга ёс, үндэснийхээ зэв нэгдлийг эрхэмлэн дээдэлж, иргэний хүмүүнлэг нийгмийг байгуулна” гэж тунхагласан байdag.¹

Монгол Улсад хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэх нийгмийн амьдралын бүх хүрээнд ардчиллыг бэхжүүлэх, эрх зүйт төрийг төлөвшүүлэх, хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх эрхэм зорилтуудыг хэрэгжүүлэхэд хууль сахиулах байгууллагуудын нийгмийн өмнө хүлээх үүрэг, хариуцлага улам нэмэгдсээр байна.

Монгол Улсын Их Хурлын 2008 оны 12 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Мянганы

¹Монгол Улсын Үндсэн хууль. –УБ, 1992 он

²Цагдаагийн албаны тухай хууль. –УБ, 2013 он 5 дугаар зүйл.



хаагч нь үйл ажиллагаагаагаа чадвартай, мэдлэгтэй, хариуцлагатай явуулснаар цагдаагийн дотоод аюулгүй байдал хангагдана гэж үзлээ.

Хоёр. Цагдаагийн байгууллагын дотоод хяналт-аюулгүй байдлын нэгжийн тухайд

Дотоод хяналт-аюулгүй байдлын нэгжийн талаар Цагдаагийн албаны тухай хуулийн 13.2-т тусгасан чиг уургийн хүрээнд алба хаагч, бусад ажилтны үйл ажиллагаанд төр, байгууллага, хувь хүний нууцын хамгаалалтад хяналт тавих, тэдгээрийн хууль тогтоомж зөрчих, гэмт хэрэг, зөрчил үйлдэхээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, судалгаа хийх, цагдаагийн алба хаагч, ажилтанд холбогдох гомдол, мэдээллийг мөрдөн шалгах, шийдвэрлүүлэх зэргээр байгууллага, алба хаагчдын аюулгүй байдлыг хангана.

Эрх зүйн шинэчлэлт, өөрчлөлт, бодлогын хувьд дэвшүүлж байгаа шинэ зорилго, зорилтуудыг хангахад удирдлагын шинэ арга барил хамгийн голлох уургийг гүйцэтгэдэг учраас цагдаагийн байгууллагын удирдлагууд байгууллагын дотоод хяналтын шинэ тогтолцоог өөрийн байгууллагад нэвтрүүлэн ажиллаж, аливаа эрсдэлээс өөрсдийн болон үйлчлүүлэгчдээ хамгаалан нийгмийн өмнө хүлээх хариуцлагаа өндөржүүлэн, үр бүтээмжтэй ажиллах нь амжилтын эхлэл байх болно.

Төрийн хяналт шалгалтын хуульд орсон нэмэлт өөрчлөлтөөр мөн төрийн байгууллагуудын дотоод хяналтыг хуульчилсан асуудал юм. Төрийн байгууллагууд дотоодо хяналттай байх нь төрийн алба хуулийн дагуу ажиллах, ард иргэдэд хүнд суртал чирэгдэлгүй үйлчлэх, үр ашигтай ажиллах бөгөөд шат шатны хяналтыг буй болгоход ихээхэн тус нэмэр болсон тогтолцоо юм.

Дотоод хяналтыг бий

болгосноор байгууллагын хууль эрх зүйн мэдлэг нэмэгдэж, хууль тогтоомжийн хэрэгжилт сайжирч, үүрэг хариуцлагаа ухамсарлах, бараа бүтээгдэхүүний чанарт ахиц гарч аюулгүй байдал хангагдах нөхцөл бүрдэх юм.

Цагдаагийн байгууллагын дотоод хяналт шалгалтын талаархи зохицуулалт нь 1993 оны цагдаагийн байгууллагын тухай хууль⁹-д “Цагдаагийн төв байгууллага нь цагдаагийн нийт байгууллага, алба хаагчийн үйл ажиллагаанд, цагдаагийн байгууллагын дарга, захирагч нар тухайн байгууллагын алба хаагчдын өдөр дутмын ажилд дотоод хяналт тавьж, хууль тогтоомж, цагдаагийн албан хаагчын ёс зүйн шаардлага, хүний эрх эрх чөлөөг зөрчих явдалтай тэмцэж, шалтгаан нөхцөлийг арилгах арга хэмжээ авна” гэж хяналт шалгалтыг эрх зүйн зохицуулалтын хувьд заасан.

Мөн онд “Цагдаагийн анги, байгууллагын ажилд туслах, шалган зааварлах үүрэг бүхий тусгай тасаг” байгууллагдаж, 1997 онд хяналт шалгалтын тусгай тасаг, 2005, 2006 онд дотоод хяналт шалгала, аюулгүй байдлын хэлтэс, дотоод аюулгүй байдлыг хангах тасаг зэрэг нэртэйгээр байгууллагдаж байсан бол 2013 онд дотоод хяналт шалгала аюулгүй байдлын хэлтэс нэртэйгээр өөрчлөн байгуулагдас.

Дотоод аюулгүй байдал, хяналт шалгалтын тогтолцоог бүрэн утгаар нь буюу хамтад нэг зүйлийн хоёрталшиг хэрэгжүүлэх нь зүйтэй бөгөөд тэгж чадаагүйн улмаас аюул учирч гарч ирсэн хортой үр дүнгээр болон эдийн засгийн хохирол гэх мэт тааварлаагүй үйл явдал гарч болох нь бий.

Дотоод хяналт-аюулгүй байдлын нэгж нь “Цагдаагийн албаны тухай” хуулийн 13.8-д заасан үйл ажиллагаа явуулахдаа

⁹Цагдаагийн байгууллагын тухай хууль –УБ, 1993 он. 51 дүгээр зүйл. үхүчингүй болсон\

холбогдох хуульд заасан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

Гурав. Цагдаагийн албан хаагч нь цагдаагийн байгууллагын дотоод аюулгүй байдлыг хангах үндсэн хүч болох нь

Цагдаагийн байгууллагын дотоод аюулгүй байдалтай цагдаагийн албан хаагчийг холбон үзвэл нэгдүгээр-т цагдаагийн албан хаагчийн өөрийн аюулгүй байдлын асуудал, хоёрдугаар-т цагдаагийн албан хаагч нь байгууллагын дотоод аюулгүй байдлыг хангах гол хүч, гуравдугаар-т цагдаагийн байгуулагасаа цагдаагийн албан хаагчийн аюулгүй байдлыг хангах буюу хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах гэсэн өөр хоорондоо уялдаа холбоо бүхий ойлголтуудыг хамруулан үзэх нь зүйтэй.

Алба хаагчдын аюулгүй байдал хамгаас чухал асуудал бөгөөд албан үүргээ гүйцэтгэж байгаад амь нас, эрүүл мэндээрээ хохирох явдал гардаг бөгөөд энэ нь цагдаагийн байгууллагын дотоод аюулгүй байдлын асуудалтай шууд хамааралтай. Ажил мэргэжлийн эрсдэлтэй байдлаараа цагдаагийн алба нь эхний байруудад ордог бөгөөд аюул эрсдэлтэй атлаа, наад зах нь хөдөлмөр хамгаалалтын хувцас, зэвсэг, тусгай хэрэгслээр хангалттай биш байгаа нь өнөөгийн Монголын цагдаагийн байгууллагын тулгамдаж буй асуудал юм.

Өнөөдрийн байдлаар 2010-2012 онд халдлага өртсөн албан хаагчдын тоо 894 буюу 43.5 хувь нь офицер, 506 буюу 56.5 хувь цагдаагийн ахлагч бүрэлдэхүүн бөгөөд 49.8 хувь нийслэл хотод, 50.2 хувь орон нутгийн цагдаагийн албан хаагч байна.

Тэгвэл цагдаагийн албан хаагчдаас сүүлийн 2 жилийн хугацаанд 3953 сахилгын арга хэмжээ авагдсаны 2358 нь 59,2 хувь нь офицер, 1625 буюу 40,8 хувь цагдаагийн ахлагч



ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

ОСОБЕННОСТИ ПРИМЕНЕНИЯ МЕР ПООЩРЕНИЯ В ИСПРАВТЕЛЬНОМ ПРОЦЕССЕ В ОТНОШЕНИИ ОСУЖДЕННЫХ ОТБЫВАЮЩИХ НАКАЗАНИЯ БЕЗ ИЗОЛЯЦИИ ОТ ОБЩЕСТВА

Соколов Сергей Алексеевич доцент кафедры
уголовно-исполнительного права
ВЮИ ФСИН России кандидат юридических наук, доцент
полковник внутренней службы

Наказания, не связанные с изоляцией осужденного от общества, несут в себе меньший заряд кары по сравнению с наказаниями, которые соединены с изоляцией осужденного от общества. Поэтому они применяются, как правило, за преступления небольшой тяжести и в качестве альтернативы лишению свободы за преступления средней тяжести. Вместе с тем наказания различаются между собой по степени их строгости, значимости и связанных с ними ограничений прав и свобод осужденных. Одни из них применяются только в качестве основных видов наказаний (обязательные работы, исправительные работы, ограничение свободы, принудительные работы), другие – в качестве как основных, так и дополнительных видов наказаний (лишение права занимать определенные должности или заниматься определенной деятельностью), а третьи – только в качестве дополнительного вида наказания (лишение специального, воинского или почетного звания, классного чина и государственных наград).

На правовую регламентацию порядка и условий исполнения и отбывания наказаний, не связанных с изоляцией осужденного от общества, в полной мере распространяют свое действие общие положения и принципы исполнения наказаний, закрепленные в нормах Уголовно-

исполнительного кодекса Российской Федерации (далее УИК РФ).

В нормах, регулирующих порядок и условия исполнения наказаний, не связанных с изоляцией осужденного от общества, общие положения и принципы исполнения наказаний находят свою конкретизацию. В частности, в них подробно регламентируются права и обязанности осужденных, а также деятельность учреждений и органов, исполняющих эти виды наказаний.

В УИК РФ впервые был сформулирован и получил свою реализацию в конкретных нормах закона принцип рационального применения мер принуждения, средств исправления осужденных и стимулирования их правопослушного поведения. Он отражает особенности исполнения различных видов уголовных наказаний с точки зрения целей и задач уголовно-исполнительного законодательства и требований (ч. 3 ст. 9 УИК РФ), указывающей, что средства исправления осужденных применяются с учетом вида наказания.

Существенной особенностью наказания без изоляции осужденного от общества является то, что оно не охватывает всего образа жизни осужденного, так как не изолирует его от общества, а устанавливает специфические права и обязанности, которые выражаются в порядке и условиях

отбывания наказания. В данном случае применение основных средств исправления носит весьма ограниченный характер, а акцент делается на рациональном применении мер принуждения к осужденным в условиях, не связанных с лишением свободы.

Рациональное применение мер принуждения закреплено в нормах, определяющих ответственность осужденных во время отбывания, например, таких наказаний, как обязательные работы (ст. 29 УИК РФ), лишение права занимать определенные должности или заниматься определенной деятельностью (ст. 38 УИК РФ), исправительные работы (ст. 46 УИК РФ), ограничения свободы (ст. 58 УИК РФ), принудительные работы (ст. 60¹⁶ УИК РФ).

Согласно Минимальным стандартным правилам обращения с заключенными (пр. 70) в каждом заведении следует иметь систему льгот и разрабатывать различные методы обращения с разными категориями осужденных, чтобы поощрять их к хорошему поведению, развивать в них чувство ответственности, прививать им интерес к их перевоспитанию и добиваться их сотрудничества.

В структуре уголовно-исполнительного права есть поощрительные нормы, которые рассматриваются учеными как средства формирования правомерного поведения



Таким образом, для повышения эффективности исполнения уголовных наказаний и их место в уголовно-исполнительном праве / Михлин А.С. // Реформа уголовно-исполнительной системы и ее правовое обеспечение. М., 1993. – С. 20.

в виде обязательных работ, исправительных работ, лишение права занимать определенные должности или заниматься определенной деятельностью, было бы целесообразно на наш

взгляд закрепить в УИК РФ меры поощрения в отношении осужденных к данным наказаниям.

ТӨР, ЗАХИРГААНЫ ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

ГЕРМАНЫ ГЭР БҮЛД ГЭРЛЭЛТИЙН ГЭРЭЭНИЙ ГҮЙЦЭТГЭХ ҮҮРЭГ, АЧ ХОЛБОГДОЛ



Бид Германы гэр бүлийн эрх зүйн зохицуулалтыг судлахыг зорьсонгүй. Харин Германы гэр бүлд гэрлэлтийн гэрээний гүйцэтгэх үүрэг, гэр бүлийн харилцаанд хэрхэн нөлөөлж буй талаар судалж, өөрийн орны гэр бүлийн эрх зүйн хэм хэмжээтэй харьцуулан, санал зөвлөмжөө дэвшүүлэн тавьсан.

Гэр бүл гэдэг бол нийгэм талаасаа хамгийн анхдагч нэгж юм. Харин хууль зүйн үүднээс авч үзвэл “Гэр бүл гэдэг бол гэрлэлтийн үр дүнд бий болсон эд хөрөнгийн бус амины болон эд хөрөнгийн эрх үүргээр холбогдсон хамтын амьдрал бүхий гэр бүлийн гишүүдийг хэлнэ”.¹ Эндээс үзэхэд гэр бүл гэдэг бол гэр бүлийн гишүүдийн хамтын амьдралаас гадна

С.Гантулга
ХСИС-ийн Цагдаагийн сургуулийн Эрүүгийн эрх зүйн тэнхимийн ахлах багш, цагдаагийн ахмад

Х.Гантулга
Нийслэлийн Засаг даргын тамгын газрын Хяналт, шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга

тэдгээрийн хооронд үүсч буй эд хөрөнгийн харилцаа юм.²

Дэлхийн улс, үндэстэн бүр нь өөр хоорондоо харилцан адилгүй өөрийн гэсэн онцлог бүхий ёс заншил, шашин шүтлэг, хэл соёлтой байдаг. Тухайлбал, Өрнө, дорнын ард түмэн өөр хоорондоо соёл, шашин шүтлэг, зан заншилаараа ихээхэн ялгаатай. Дорно дахины улс орнуудын ард түмний өдөр тутмын амьдралд Буддын сургаал нэвт шингэсэн байдаг. Энэ ч утгаараа ёс суртахууныг өндөрт тавьж, эцэг эхийн сургаалыг хүндэтгэдэг. Харин Өрнийн ард түмэн христийн сургаалд бишрэн олон зуун жилийн турш зан үйлдээ төлөвшүүлж, үр хүүхдээ өсгөн хүмүүжүүлж ирсэн. Ингэснээр хүүхэд, залуучуудын сэтгэлээ чөлөөтэй хөгжин бие даан шийдвэр гаргах чадвартай болсон байдаг. Энэ зан үйл нь Европчууд тэр тусмаа Германы гэр бүлийн харилцаанд тусгалаа олжээ.

Германы залуучуудын дийлэнх

хувь нь 25-40 насандаа гэрлэж, гэрлэх ёслолоо гэрлэх ёслолын ордон эсвэл сүмд үйлддэг. Гэрлэгчид³ нь гэр бүл болсны дараа эсвэл гэр бүл болсноос хойш 5 жилийн дотор гэрлэлтийн гэрээг байгуулдаг байна. Энэхүү гэрээг ХБНГУ төдийгүй Австри, Швейцарь, Дани зэрэг Европын хэд хэдэн улсуудад гэрлэгчид байгуулдаг байна.

Гэрлэлтийн гэрээ гэж гэрлэгчид хооронд хамтын эд хөрөнгөтэй холбоотойгоор талуудын сайн дурын үндсэн дээр хийгдсэн бичгийн тохиролцоо юм.⁴ Гэр бүлийн хамтын амьдрал бий болоход тодорхой эд хөрөнгө бий болдог, мөн гэр бүлийн хамтын амьдрал дуусах эсвэл гэрлэгчдийн хэн нэг нь нас барах тохиолдолд дундын эд хөрөнгөтэй холбогдсон маргаан үүсдэг. Иймээс гэрлэлтийн гэрээг

¹Гэр бүлийн тухай хууль.УБ.,1999.,№12, “Гэр бүлийн тухай хууль”.УБ.,1999.,3 р зүйл “Гэрлэгчид” гэж гэрлэлтээр холбогдсон харилцан тэгш эрх эдэлж, адил үүрэг хүлээх нөхөр, эхнэрийг;

²“Buergerliche Gesetz Buch” /komentarische/ 1999.,1297-р зүйл

¹Төрийн мэдээлэл.УБ.,1999.,№12, “Гэр бүлийн тухай хууль”.УБ.,1999.,3 р зүйл

²“Buergerliche Gesetz Buch” /komentarische/ 1999.,1297-р зүйл



гэрлэлтийн гэрээний талаар огт ойлголтгүй, 6.6% буюу 2 иргэн бага зэргийн мэдлэгтэй, 3.3% буюу 1 иргэн хангалттай ойлголт, мэдлэгтэй гэж тус тус хариулсан.

Гэрлэлтийн гэрээг үндэсний хууль тогтоомжид тусган өгч, эрх зүйн орчинг бурдүүлэх талаар судалгаанд оролцогчдын 80% буюу 24 иргэн дэмжиж, 13.3% буюу 4 иргэн цаг хугацааны хувьд хараахан болоогүй, 6.6% буюу 2 иргэн татгалзсан байна.

Дээрх судалгааны үр дүнгээс үзэхэд гэр бүлийн эд хөрөнгийн зохицуулалтын талаар хүмүүсийн ойлголт, мэдлэг дутмаг байгаа бөгөөд гэрлэлтийн гэрээг үндэсний хууль тогтоомжид тусган өгч, эрх зүйн орчинг бурдүүлэхийг дэмжсэн байна.

Энэ бүхнээс үзэхэд гэрлэлт гэдэг бол нэг талаасаа гэрлэгчдийн ариун нандин холбоон дээр үндэслэгдсэн ураг төрөл, садан төрөл, үр хүүхэд, тэжээн тэтгэхтэй холбоотой харилцаа ба нөгөө талаас эд хөрөнгийн холбоотой харилцаа юм. Монголчууд бид барууныхныг ялангуяа Германчуудын хувцаслалт, биеэ авч явах байдал, унах машин зэргийг даган дуурайх дуртай. Яагаад Германы төдийгүй Европын улс орнуудын гэр бүлийн эрх зүйд чухал байр суурийг эзэлдэг, ач холбогдол бүхий энэхүү “Гэрлэлтийн гэрээ”-г өөрийн орны онцлог хэв шинжид зохицуулан Гэр бүлийн тухай хууль тогтоомжиндоо тусгаж, эрх зүйн орчинг нь бурдүүлж өгч болохгүй гэж.

Улс орныхоо ирээдүй хойч

болсон охид, бусгүйчүүд нь баян гадаадын иргэн эсвэл компанийн захирал /Boss/, залуучууд нь мөнгө, байр, машинтай хөгшин эмэгтэйтэй гэрлэж, бүгдийг нь чаддагүй юмаа гэхэд орон сууц, автомашиныг нь салгаж аваад салах бодол өвөрлөн, битүүхэндээ санаа алдан бас ч хүү горьдлого тавин явдаг гэдэгт итгэлтэй байна.

Сүүлийн жилүүдэд гэр бүл салалт эрс нэмэгдэж, тэдгээрийн дийлэнх хувь нь дундын эд хөрөнгийн маргаантайн улмаас шүүхэд хандаж шийдвэрлүүлсэн байна. Улсын хэмжээнд 1998 онд 1637 гэр бүл гэрлэлтээ цуцлуулж байсан бол 2013 онд 2579 болж, даруй 57.5%-иар өсч, гэр бүл цуцлалт жил дараалан өссөн үзүүлэлттэй байна.

2013 онд 2579 гэр бүл гэрлэлтээ цуцлуулсан нь өмнөх онтой харьцуулахад 342 буюу 15.28%-иар өссөн, цаашид гэр бүл салалтын тоо өсөх хандлагатай байна.

Гэрлэлтийн гэрээг өөрийн орны хууль тогтоомжид тусгаж, эрх зүйн орчинг бурдүүлэхийг нийгэм, цаг үе биднээс шаардаж байна. Иймд Монгол улсын үндэсний хууль тогтоомжид Германы гэрлэлтийн гэрээг тусгаж өгснөөр гэр бүл салалт багасч, хүүхэд өнчрөх⁵, тэнүүчлэх, хараа хяналтгүй үлдэх явдал буурах, “хуурамч” гэрлэлтийн улмаас

иргэд эд хөрөнгө болон сэтгэл зүйн хувьд хохирох явдал эрс багасах, шүүхийн ачаалал багасах, нийгмийн сөрөг сэтгэл зүй үгүй болох, өв залгамжлал маргаангүй болох зэрэг ач холбогдолтой.

Бид судалгааны үр дүндээ үндэслэн дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Гэрлэлтийн гэрээг өөрийн орны онцлог хэв шинжид нийцүүлэн Гэр бүлийн тухай Монгол улсын хуульд тусгах,

2. Энэ гэрээний үүрэг, ач холбогдлын талаар сургалт сурталчилгаа эрчимтэй явулах

3. Их, дээд сургууль, коллеж болон ерөнхий боловсролын сургуулиудын сургалтын хөтөлбөрт гэрлэлтийн гэрээний ойлголт, мөн чанар, нийгэмд гүйцэтгэх үүрэг, ач холбогдол, байгуулах үндэслэл, журмын талаар мэдлэг олгох хичээлийг оруулах зэрэг болно.

Ном зүй:

1. “Монгол Улсын Үндсэн хууль”. УБ., 1992
2. “Монгол Улсын Иргэний хууль”. УБ., 2002
3. “Монгол Улсын Гэр бүлийн хууль”. УБ., 1999
4. “Buergerliche Gesetz Buch” 1896
5. “Buergerliche Gesetz Buch” / komentarische/ 1999
6. “Жендер судалын удиртгал” УБ, 2003
7. Т.Мөнхжаргал “Иргэний эрх зүй” УБ, 2002
8. Das Buergerliche recht <http://www.-recht.de/ehevertrag-2.html>

⁵Гэр бүлээ цуцлуулагчдын хүүхдийн нас: 0-4 насны /24- 7.4%, 5-9 насны /91-28.2%, 10-14 насны /125- 38.9%, 15-18 насны /82-25.4%/. О.Огтонтуяа. “Шүүхийн журнаар гэрлэлт цуцлах нь гэрлэлт дуусгавар болох нөхцөл мөн”//Монголын төр, эрх 2008., №3 /55/



тогтолцоонд оруулсан билээ.

Хэдийгээр Монгол улсын Үндсэн хуулиар иргэд нь эрхээр хангагдаж, төрийн эрх мэдлийг хувиарласан ч түүнийг хамгаалах механизмыг бий болгох нь чухал билээ. Энэ асуудлаар доктор /Sc.D/, профессор Н.Лүндиндорж“...иргэд нь эрхээр хангагдаагүй, төрийн эрх мэдлийг хувиараагүй нийгэмд Үндсэн хууль байдаггүй. Ийм орны Үндсэн хууль нь хуурмаг Үндсэн хууль буюу зүгээр л хууль зүйн текст юм. Үүнийг хоёрхон зүйлээр л шалгадаг бөгөөд 1-рт тухайн улс арчилсан дэглэмтэй байх уу, 2-рт тухайн улсын эрх зүйн тогтолцоо ямар байх вэ гэдгээс хамаардаг. Эрх зүйн газрын зураг гэж бий Монголын эрх зүйн тогтолцоо ямар өнгөтэй байх вэ гэдгийг Separation of power шийднэ. Монгол улсад төрийн эрх мэдэл бүрэн хувиарлагдаагүй байна. Тийм байж хүний эрх эрх чөлөөг яж хангаад байгаа юм бэ гэвэл энэ бол глобалчлалын нөлөө юм. Энэ их удаан үргэлжлэхгүй.

Үүний үр дүнд:

1. Арчилал хагас болно
2. Хагас эрх чөлөө болно
3. Хууль эрх зүйт бус болно” гэж төрийн эрх мэдэл хувиарлах онолын лекцэндээ дурдсан байдаг.

Нийгмийн амьдрал улам баялаг болж хууль тогтоомжийн зохицуулалт улам өргөн хүрээг хамарч байгаа ч нийгмийн бүхий л харилцааг хуульчлах нь эргээд **rul of law**-г хууль дээдлэх ёс гэсэн буруу ойлголт ард түмний дунд төрж муу хуулийг ч биелүүлнэ гэсэн ойлголтод хүрнэ. Ингэснээр эрх зүйт төр, эрх зүйт хуулийн шинж мөн чанар алдагдахад хүрнэ.

Тэгвэл өнөөдөр бид 1960 оны Үндсэн хуулинд Монгол улсын иргэн хувийн өмчтэй байхыг хориглосон шиг 2012 онд хувийн өмчийг хуулиар биш захиргааны актаар хязгаарлах тохиолдол гарч байна. Энэ бол **rul of law**ши.

2012 оны 08-р сарын 22-ны өдрийн Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын ээлчit бус

хуралдаанаар “Улаанбаатар хотын замын хөдөлгөөний хэт ачааллаас урьдчилан сэргийлэх, иргэдийг нийтийн тээврийн хэрэгслэлээр зорчуулах боломжийг нэмэгдүүлэх зарим арга хэмжээ авах тухай” гэсэн 02/8 дугаар тогтоол дэмжигдэж 2012 оны 08 дугаар сарын 27-ноос 10 дугаар сарын 27-ны өдрийг хүртэл 1 ба 6-аар төгссөн улсын дугаартай автомашин даваа гаригт, 2 ба 7-аар төгссөн улсын дугаартай автомашин мягтар гаригт, 3 ба 8-аар төгссөн улсын дугаартай автомашин лхагва гаригт, 4 ба 9-өөр төгссөн улсын дугаартай автомашин дүрэв гаригт, 5 ба 0-аар төгссөн улсын дугаартай автомашин баасан гаригт замын хөдөлгөөнд оролцохгүй гэсэн агуулга бүхий тогтоол гарсан билээ.

Ингээд тогтоолын хэрэгжилтийн туршилтын хугацаа дуусч 2012 оны 11-р сарын 16-ны өдрийн Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн 4/14 дугаар тогтоолоор дээрхи шийдвэрийг хэвээр үлдээж үргэлжлүүлэн зохион байгуулах тухай тогтоол гаргасан.

Уг захиргааны актын эрх зүйн үндэслэлийг шалгавал “... хуульд өөреөр заагаагүй бол нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн амьдралын тулгамдсан асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх эрхтэй”⁵, “Хурал, Засаг даргаас хууль тогтоомжид заасан эрх хэмжээнийхээ хүрээнд гаргасан шийдвэр тухайн нутаг дэвсгэрт хүчин төглөдөр дагаж мөрдөгдөх бөгөөд түүнийг холбогдох байгууллага, албан тушаалтан, иргэд заавал биелүүлнэ”⁶, “Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн Хурал нь Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль,

⁵Монгол улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль. УБ., 2006 он, 20 дугаар зүйлийн 20.1.7

⁶Монгол улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль. УБ., 2006 он, 39 дүгээр зүйлийн 39.1

холбогдох бусад хууль тогтоомжид заасан бүрэн эрх эдлэхээс гадна дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

1/ нийслэлтэй холбогдсон асуудлаар хууль тогтоомжид нийцүүлэн бие даан шийдвэр гаргах;

2/ нийслэлд хэв журам сахиулах, хотын аж ахуй, оршин суугчдын нийгэм, соёлын асуудлаар нийтээр дагаж мөрдөх журмыг хууль тогтоомжид нийцүүлэн гаргаж, биелэлтэд хяналт тавих;

3/ нийслэл, түүний оршин суугчдын нийтлэг ашиг сонирхлыг хөндсөн, өөрийн эрх хэмжээнд шийдвэрлэх боломжгүй асуудлыг шийдвэрлүүлэхээр Монгол Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Засгийн газар, холбогдох бусад байгууллагад санал тавих;

4/ нийслэлийн нийгэм, эдийн засгийн хөгжил, хот байгуулалт, хүрээлэн байгаа орчныг хамгаалах, хүн амын үйлчилгээтэй холбогдох асуудлаар төрийн захиргааны төв байгууллагад санал тавьж шийдвэрлүүлэх;

5/ нийслэлийн хэмжээнд тэмдэглэлт ой, баяр ёслол тэмдэглэх, байгууллагад нэр өгөх, нэрэмжит болгох, хөшөө дурсгалын цогцолбор байгуулах асуудлаар өөрийн санаачилгаар болон иргэд, байгууллагын саналыг үндэслэн шийдвэр гаргах.” гэсэн хуулийн зүйл заалтыг үндэслэжээ.

Монгол улсын Үндсэн хуулийн 4 дүгээр бүлгийн 63-р зүйлийн 63.2-т “...хурлын тогтоол, засаг даргын захирамж нь хууль тогтоомж, ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газар, харьяалах дээд шатны байгууллагын шийдвэрт нийцэн байх бөгөөд түүнийг тус тусын нутаг дэвсгэрт хүчин төглөдөр дагаж мөрдөнө” гэж заасныг үндэслэн Монгол улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1-т “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай

Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хууль. УБ., 1994он, 8-р зүйлийн 8.1